СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

УЛААНБААТАР ХОТ
2024 он

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ АГУУЛГА

Удиртгал..... 2

1. Төлөвлөх үе шат..... 4

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх болсон шалтгааныг тогтоох..... 4

1.2. Үнэлгээний хүрээг тогтоох..... 5

1.3. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох, томьёолох, хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох..... 5

1.4. Мэдээлэл цуглуулах..... 6

1. Хэрэгжүүлэх үе шат..... 7

2.1. Хэрэгжүүлэх үе шат..... 7

2. Үнэлэх үе шат..... 9

3.1. ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 1: ХУУЛИЙН НЭР ТОМЪЁО..... 9

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 2: СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРИЙН БОДЛОГО 13

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 3: ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ 25

3.4 ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 4: ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСГҮҮРИЙН ТӨСӨЛ 37

3.5 ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 5: ҮНЭ, ТАРИФ 41

3.6 ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 6: МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ, ХАРИУЦЛАГА 52

УДИРТГАЛ

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ /цаашид "үнэлгээ" гэх/ хийх нь хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх болон харьцуулан үнэлэх ажиллагаа бөгөөд энэхүү үнэлгээ хийх ажлын зорилт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль нь 2007 онд 6 бүлэг 15 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд 2008, 2011, 2012, 2015 онд 3 удаа, 2019, 2022 онуудад нийь 8 удаа нэмэлт өөрчлөлт орж байснаас 2015, 2019 онуудад томоохон нэмэлт өөрчлөлтүүд орж байжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Анх батлагдсан он	2007 он
Бүлгийн тоо	6
Зүйлийн тоо	14
Заалтын тоо	104
Өөрчлөлт орсон онууд	2008 онд – 3 заалт, 2011 онд - 1 заалт, 2012 онд – 3 заалт, 2015 онд – 17 заалт, 2019 онд - 27 заалт, 2022 онд - 2 заалтанд тус тус өөрчлөлт оруулсан
Нийт өөрчлөгдсөн заалт	Нийт 53заалт (50,96%)
Нэмэлт оруулсан заалтууд	14
Өөрчлөн найруулсан заалтууд	33
Хүчингүй болгосон заалтууд	8

2007 онд анхлан батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль нь сэргээгдэх эрчим хүчний салбарыг үнэ, тарифын бодлогоор дэмжих, зөвхөн төвийн нэгдсэн

сүлжээнд холбогдох сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс гадна, түгээх сүлжээнд холбогдох бие даасан үүсгүүрүүдийг хөгжүүлэх үзэл баримтлалтай байсан байна. Гэвч сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх бие даасан үүсгүүрийн үзэл баримтлалыг огт хэрэгжүүлж чадаагүйн дээр, ийм төрлийн үүсгүүрийн үйлдвэрлэсэн эрчим хүчний үнэ, тарифын бодлогын заалтуудыг хүртэл хүчингүй болгосон байна.

Анх хууль батлагдах үед тавьж байсан зорилт болох 2020 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмжээг эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадлын 20 – 25 хувьд хүргэх зорилтын тухайд өнөөдөр Монгол Улс 16 хувьд хүрсэн байгаа нь чамлахаар амжилттай үзүүлэлт байна. Гэвч дэлхий дахины ногоон шилжилт хийх зорилгод нэгдсэний хувьд сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, түүний нийт системд эзлэх хувийг өсгөх зайлшгүй шаардлага өдөр бүр нэмэгдсээр байгаа юм.

Салбарын өнөөгийн нөхцөл байдал, үүсээд буй асуудлууд, тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтын ононвчтой байдал, маргаан үүсч буй шалтгаан, үр дагаврыг үнэлэх, сайжруулах, боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагыг тогтоосон аргачлалын дагуу судалж, үнэлэлт, дүгнэлтийг тайланд энэхүү тусгасан болно.

1. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ БОЛСОН ШАЛТГААНЫГ ТОГТООХ

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль нь тухайн салбарын харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох шаардлагатай. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохдоо “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д тусгасан дараах үндэслэлүүдийг авч үзсэн болно.

Аргачлалын заалт	Шалтгаан
3.2.1 тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал;	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн зохицуулалттай хамааралтай шүүхийн практикт үүсч буй асуудлууд, голлох маргаанууд, шийдвэрлэсэн байдал зэргийг салбарын хэмжээнд судалгаагаар нэгтгэн харуулж, зохих үнэлэлт дүгнэлт өгөх;
3.2.2 хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол;	Сэргээгдэх эрчим хүчний салбарт тулгамдаж буй дараах асуудлуудын хүрээнд хууль эрх зүйн зохицуулалтын үр дагаврыг үнэлэх: 1. Хуулийн нэр томъёо 2. Сэргээгдэх эрчим хүчний төрийн бодлого 3. Тусгай зөвшөөрөл 4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн төсөл, эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ 5. Үнэ, тариф 6. Маргаан шийдвэрлэлт, хариуцлага Хуулийн зүйл, заалт бүрийн хэрэгжилтийг үнэлснээр дараах нөхцөл байдлууд байгаа эсэхийг илрүүлэх: ▪ Шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдал; ▪ Тодорхойгүй, ойлгомжгүй, хэт ерөнхий зүйл заалтууд байгаа эсэх;

	▪ Чухал ач холбогдолтой гол харилцаануудыг дүрэм, журмаар зохицуулахаар заасан; ▪ Цаг үе, нийгмийн хөгжлийн өөрчлөлттэй хамааралтай шинээр болон шинэчлэн тогтоох харилцаанууд бий болсон;
3.2.4 нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан;	Эрчим хүчний салбарын шинэчлэл, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар салбарын оролцогч талуудаас ирүүлсэн саналуудыг агуулга, зүйл, заалтаар ангилан нэгтгэж, үнэлэх

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭГ ТОГТООХ

1. Хуулийн нэр томъёо
2. Сэргээгдэх эрчим хүчний төрийн бодлого
3. Тусгай зөвшөөрөл
4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн төсөл
5. Үнэ, тариф
6. Маргаан шийдвэрлэлт, хариуцлага

1.3 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ, ТОМЬЁОЛОХ, ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭРИЙГ СОНГОХ

Тухайн хуулийн зүйл, заалтаар зохицуулагдаж буй харилцааны онцлог, хэрэгжилтийг хэрхэн хэмжиж, үнэлэх боломжтой эргээс хамаарч шалгуур үзүүлэлт харилцан адилгүй байж олно. Аргачлалд тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээс зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөхүйц байдал, практикт нийцсэн байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг голчлон хэрэглэж үнэлгээг хийсэн.

Мөн тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилтийн үр нөлөөг тодорхой, оновчтой илэрхийлэхэд чиглүүлэх таамаглал, асуумжийг томьёолсон.

Хуулийн хэрэгжилтийн харьцуулалтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын хэлбэрийг нийтлэг сонгосон.

Үнэлэх үе шатанд хуулийн бүлэг, заалт бүрээр тодорхойлсон болон томьёолсон шалгуур шалгуур үзүүлэлтүүд, харьцуулах хэлбэрийг нэгдсэн хүснэгт байдлаар харах боломжтой.

1.4 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГЫГ СОНГОХ

Сэргээгдэх эрчим хүчний хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ дараа мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах аргыг сонгохоор төлөвлөсөн.

	- Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, экспертүүдтэй биечлэн уулзах, хэлэлцүүлэг хийх; - Эрчим хүчний салбарын хуулиудын шинэлэлд цахим хуудсаар асуулга, санал авах; - Эрчим хүчний салбарын байгууллагуудаас хуулийн хэрэгжилт, өөрчлөлт оруулах талаар албан бичгээр санал авах; - Эрчим хүчний салбарын төрийн байгууллагууд болон компаниудаас тодорхой статистик тайлан, судалгаа, мэдээллүүдийг цуглуулах; - Салбарын тодорхой чиг үүргийн байгууллагуудаас тайлан танилцуулга авах, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах; - Хуультай холбоотой шүүх дээр үүсдэг маргаанууд, гол асуудлуудын талаар хуулийн мэргэжлийн холбоо, хуульчдаас санал, зөвлөмж авах; - Эрчим хүчний салбарын компаниудын цахим систем, веб хуудаснаас мэдээлэл авах;

2. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1. ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ

Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх, хуулийн зүйл заалтуудын хэрэгжилтийн үр дагаврыг тодорхой нотлогдсон тоо баримтаар илэрхийлэх зорилгоор нийт 24 нэр төрлийн мэдээллүүдийг төрийн байгууллагууд, салбарын компаниудаас гаргуулан авах ажлыг зохион байгуулсан.

Байгууллага компаниудаас ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгах, үнэн бодит байдлыг хянах, бусад эх сурвалжуудтай харьцуулах зэргээр өгөгдөлд боловсруулалт хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мэдээлэлд хийсэн боловсруулалт дүн шинжилгээ, тайлан графикуудыг хуулийн зүйл заалтын хэрэгжилтийн үнэлгээний зохих хэсэгт нотломж болгон ашигласан болно.

№	Мэдээлийн нэр	Хамрах хугацаа
Эрчим хүчний яам		
1	Цахилгаан эрчим хүчээр хангагдахаар техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгохыг хойшлуулсан, олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал /1МВт-аас дээш/	2022-2024он
2	Дулааны техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал (1 Гкал/цагаас дээш)	2022-2024 он
Эрчим хүчний зохицуулах хороо		
1	Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгахтай холбоотой гарсан шүүхийн маргааны судалгаа	2019-2024
2	Эх үүсвэрүүдийн цахилгааны суурилагдсан хүчин чадал, өөрчлөлтийн хамт	2014-2024он
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний болон дулаан түгээлтийн мэдээлэл	2014-2024он
4	Эрчим хүчний барилга байгууламж буюу шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олгосон судалгаа, үүнээс баригдсан эх үүсвэрийн судалгаа	2014-2024он
Диспетчерийн үндэсний төв		
1	Эх үүсвэрүүдийн өвлийн их, зуны бага ачаалалд оролцсон судалгаа (хоногийн ачааллын графикаар)	2023 он
2	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгааны хэрэглээг хангахад эх үүсвэрүүдийн оролцсон судалгаа, энергиэр	2019-2023 он
3	Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй байгуулсан худалдах, худалдан авах гэрээний судалгаа	2013-2024

№	Мэдээлийн нэр	Хамрах хугацаа
Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд		
1	Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, батлагдсан үнэ тарифын судалгаа	2022, 2023,2024ХБГ
2	Үндсэн тоноглолын насжилтын судалгаа	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
3	Цахилгаан дамжуулах,түгээх сүлжээнээс техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгохыг хойшлуулсан, олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал /1МВт-аас доош/	2022-2024 он
4	Дулааны техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал (1 Гкал/цагаас доош)	2022-2024 он
5	Техникийн өргөтгөл шинэчлэл, хүчин чадал нэмэгдүүлэх зорилгоор гадны банкнаас авсан зээлийн талаарх мэдээлэл	Зээлийг нь төлж дуусаагүй байгаа төслүүдийн мэдээлэл
6	Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, талаар 3 - 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	2021-2023
7	Хэрэглэгчдээс ирсэн гомдол, саналын тоо	(2022,2023,2024 ХБГ)
8	Цахилгаан дулааны эрчим хүчний чанарын шаардлага хангаагүйгээс үүдэн хэрэглэгчид учирсан хохирлын талаар статистик тоо	(2022,2023,2024 ХБГ)
9	Хамгаалалтын зурвас зөрчсөн иргэн, хуулийн этгээдүүдийн статистик тоо, судалгааг газрын гэрчилгээтэй, гэрчилгээгүй эсэх судалгаа	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
10	Цахилгаан дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлтийн талаарх мөрдөж ажиллаж байгаа дүрэм журам, норм ба дүрэм, стандартын нэр	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх
11	Эрчим хүчний хуулийн 29.1.9 дах заалт, 30.1.10 дах заалт, 30.1.11 дах заалттай хамааралтай иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, санал, маргааны талаар судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
12	1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд хооронд үүссэн шүүхийн маргааны судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
13	1.2 Хамгаалалтын зурвастай холбоотой гарсан шүүхийн маргаан, шийдвэрлэлтийн байдал	(2022,2023,2024 ХБГ)
14	Эрчим хүчний тухай хуулийн 30.1.8 дах заалтын дагуу засвар үйлчилгээ хийдэггүй хэрэглэгчдийн судалгаа, гарч буй хүндрэлүүдийн тайлан	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
15	Орлого цуглуулалт, өр төлбөртэй хэрэглэгчдийн статистик судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
16	Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй байгаа айл өрх, ААН-н тоо	2022-2024 он
17	Ухаалаг тоолуурын судалгаа	2024 оны байдлаар

3. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 1: ХУУЛИЙН НЭР ТОМЪЁО

Хуулийн заалт	4.1.1."сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр" гэж нар, салхи, усны эрчим болон газрын гүний дулаан, биомасс зэрэг байгалийн байнга нөхөн сэргэх нөөцийг; 4.1.2."биомасс" гэж ургамал, органик хаягдлыг; 4.1.3."сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр" гэж энэ хуулийн 4.1.1-д дурдсан эх үүсвэрийг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх байгууламжийг; 4.1.4."сэргээгдэх эрчим хүч" гэж энэ хуулийн 4.1.3-т заасан байгууламжийг ашиглан үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг; 4.1.5."сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр" /цаашид "бие даасан үүсгүүр" гэх/ гэж эрчим хүчний дамжуулах сүлжээнд холбогдоогүй дан болон хосолсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг; 4.1.6."үйлдвэрлэгч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 13.1-д заасан цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг; 4.1.7."дамжуулагч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 14.1-д заасан цахилгаан, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг; 4.1.8."хэрэглэгч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.19-д заасан иргэн, хуулийн этгээдийг. *<u>/Энэ заалтад 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u>* 4.1.9."дэмжих тариф" гэж сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг. *<u>/Энэ заалтыг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/</u>* 4.1.10."төсөл шалгаруулалт" гэж эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг тогтоосон техникийн нөхцөл, нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үнийн саналаар өрсөлдүүлэн сонгон шалгаруулах ажиллагааг;

	/Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 4.1.11."төсөл хэрэгжүүлэх баталгаа" гэж төсөлд оролцогч нь төслийг бүрэн биелүүлэхийг баталгаажуулж ирүүлсэн банкны баталгаа, банканд байршуулсан мөнгөн хөрөнгийг; */Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./* 4.1.12."Диспетчерийн үндэсний төв" гэж Эрчим хүчний тухай хуулийн 10.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийг. */Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./*
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – хангалттай ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – хангалтгүй ▪ Практикт нийцэж байгаа байдал – хангалтгүй ▪ Бусад үр дагавар – эрчим хүчний салбарын нэр томъёо нэгдмэл, нэг мөр ойлгогдохуйц биш бол хуулийн зөрчил, үл ойлголцол, тодорхойгүй байдлыг бий болгох сөрөг үр дагавартай
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Эрчим хүчний болон сэргээгдэх эрчим хүчний салбарын нэр томъёог оновчтой, зөв зүйтэй, нэг мөр, жигд томъёолж, агуулгыг зөв, бүрэн гүйцэд тодорхойлж чадасан эсэх?
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	

Үнэлсэн байдал

Эрчим хүчний тухай хууль болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиуд нэг салбарын хуулиуд хэдий ч нэр томъёог ялгавартайгаар өөр өөрөөр томъёолсон байна. Тухайлбал,

1. эрчим хүчний нөөц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр;
2. эрчим хүчний эх үүсвэр болон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр;
3. бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч болон сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр;
4. эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ болон цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ;

1. Эрчим хүчний тухай хуулийн 3.1.2 дахь заалтад “эрчим хүчний нөөц" гэж цахилгаан, дулаан үйлдвэрлэх зориулалтаар ашиглаж болох бүх төрлийн түлш, сэргээгдэх болон бусад эх үүсвэрийг ойлгоно гэж заасан. Гэтэл Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд Эрчим хүчний тухай хуулийн энэхүү заалтын дагуу нөөц гэж томъёологдох нар, салхи, усны эрчим болон газрын гүнийн дулаан, биемасс зэрэг байгалийн нөхөн сэргээх нөөцийг гэж томъёолсон нь Эрчим хүчний тухай хуультай зөрүүтэй томъёолол болсон байна. Эрчим хүчний тухай хуульд “эх үүсвэр”-ийг эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа барилга байгууламжийг ойлгоно хэмээн тодорхойлсон. “Эх үүсвэр” гэдэг нэр томъёо “нөөц” гэдэг нэр томъёотой ижил утгатай бөгөөд олон улсад, жишээлбэл англи хэлээр “resources”, орос хэлээр “ресурсы” буюу нөөц, баялаг, эх үүсвэр гэдэг үг, ойлголт юм. Үүнээс харахад Сэргээгдэх эрчим хүчний хуульд “эх үүсвэр” гэдэг нэр томъёог илүү оновчтой, зөв зүйтэй хэрэглэсэн байна.

2. Эрчим хүчний тухай хуулийн 3.1.2 дахь заалтад “эрчим хүчний эх үүсвэр” гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг гэж тодорхойлсон бол, яг ижил энэ ойлголтыг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд “эрчим хүчний эх үүсгүүр” гэж тодорхойлжээ. “эх үүсвэр” гэдэг нэр томъёо дээр дурдсанчлан илүү нөөц, баялаг, ресурс гэдэг ойлголтыг тодорхойлоход тохиромжтой тул эрчим үйлдвэрлэж байгаа байгууламж буюу эрчим хүч үүсгэн бий болгож байгаа, англи хэлээр “generator”, орос хэлээр “генератор”, орчуулбал “үүсгүүр” гэж томъёолсон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн томъёолол илүү зөв, оновчтой байна.

3. Эрчим хүчний тухай хуулийн 3.1.33-т “бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч”, харин Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 4.1.5-д “сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр” томъёолсон ойлголтууд нь нэг ойлголтыг “үйлдвэрлэгч”, “үүсгүүр” гэж өөр өөр нэр томъёогоор томъёолсноос гадна агуулгын тодорхойлолтыг нь хүртэл зөрүүтэйгээр тодорхойлжээ. Эрчим хүчний тухай хуульд “эрчим хүч экспортлох, эсхүл гэрээний хугацаанд хэлцлийн үнээр эрчим хүч нийлүүлэх хувийн хэвшлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай эрчим хүч үйлдвэрлэгчийг” ойлгоно гэсэн бол, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд “эрчим хүчний дамжуулах сүлжээнд холбогдоогүй дан болон хосолсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг” ойлгоно гэж тодорхойлсон нь хоорондоо нэлээд ялгаатай, нэг зүйлийг өөр өөр талаас нь тайлбарласан байна. Эрчим хүчний тухай хуульд баримтлах үнэ, тарифаа хэрхэн тогтоох, хэн хөрөнгө оруулсан гэдгийг онцолж тодорхойлсон бол Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд дамжуулах сүлжээнд буюу нэгдсэн сүлжээнд холбогдоогүй гэдэг талыг нь онцолж тодорхойлолтоо хуульчилсан байна. Олон улсын жишигт “бие даасан үүсгүүр” гэдэгт энэхүү 2 тодорхойлолтын аль альных нь онцолж заасан шинжүүдийг бүгдийг нь нэгтгэсэн ойлголтыг илүү түлхүү хэрэглэдэг байна. Энэхүү нэр томъёоны “эх үүсвэр”, “үйлдвэрлэгч”, “үүсгүүр”-н талаар энэхүү үнэлгээний хүрээний 2 дахь хэсэгт дүгнэлт бичсэн байгаа болно. Иймд энэхүү ойлголтыг нэгдүгээрт, нэр томъёог нь оновчтой

хувилбарыг нь сонгох, хоёрдугаарт, агуулгыг нь бүрэн гүйцэд тодорхойлж салбарын 2 хуульд нэг мөр жигдилж хэрэглэх шаардлагатай байна.

4. Эрчим хүчний тухай хуульд “эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” буюу цахилгаан, дулаан бусад эрчим хүчийг бүгдийг нь хамруулан ойглгохоор гэрээ байхад Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний төрлүүдээс зөвхөн “цахилгаан” хэмээн тусгайлан заасан нь үзэл баримтлал, хуулийн үйлчлэх цар хүрээний хувьд нарийсгасан, зөрчилтэй заалт болсон байна. Иймд үүнийг цаашид “цахилгаан” гэдэг хэсгийг нь хасч хуульчлах шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.6.4 эх заалт болон 10 дугаар зүйлд заагдсан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг “цахилгаан эрчим хүч” гэж эрчим хүчний төрлүүд дотроос зөвхөн цахилгаанд хамааруулан хуульчилсан нь тухайн хуулийн хамрах хүрээг нарийсгасан байна. Гэтэл тус хууль нь “Сэргээгдэх эрчим хүчний тухай” буюу эрчим хүчний бүхий л төрлийг хамарсан өргөн цар хүрээтэй хууль юм. Түүнчлэн тус хуулийн үйлчлэх хүрээг тогтоосон 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан Монгол Улсын нутаг дэвсгэрт цахилгаан, дулаан үйлдвэрлэж, нийлүүлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчилнэ. /Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./” гэж зааснаас үзэхэд зөвхөн цахилгаан бус, мөн дулааны эрчим хүчийг хамруулахаар байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 2: СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРИЙН БОДЛОГО

Монгол Улсын өргөн уудам газар нутаг, байгаль цаг уурын нөхцөл нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх асар их боломжийг агуулж байдаг. Дэлхий дахин уур амьсгалын өөрчлөлтийн улмаас “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээр”-ийг байгуулж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар дэлхийн дулаарлыг хязгаарлаж 2050 гэхэд дэлхий нийтээрээ “net zero” буюу тэг ялгаралтанд хүрэх зорилго тавьсан. Энэхүү хэлэлцээрийг Монгол Улс 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр соёрхон баталж хууль гаргасан байна. Энэхүү зорилгод хүрэхийн тулд сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх нэн шаардлагатай байгаа билээ. Энэхүү салбарт баримтлах төрийн бодлогыг үндэслэл тооцоололтой, нэгдмэл цогц, тогтвортой, салбарын бусад зорилтуудтай уялдаа холбоотойгоор боловсруулж батлах нь нэн чухал байна.

Иймд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг тогтоохдоо хуулийн хэрэгжилтэнд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг сонгох үүднээс тус салбарын төрийн бодлого боловсруулах, батлуулахтай холбоотой асуудал, түүнтэй холбоотой заалтуудыг нэг үнэлгээний хүрээ болгон үнэлэхээр тогтсон болно.

Хуулийн заалт	5.1.Улсын Их Хурал сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, улсын төсвийн хөрөнгөөр баригдсан бие даасан үүсгүүрийг орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. 5.2.Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, бие даасан үүсгүүрээр хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангах сумдын жагсаалтыг батлана. 5.3.Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.3.1.сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх; 5.3.4.сэргээгдэх эрчим хүчний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах.

	5.3.9.төсөл шалгаруулалтыг зохион байгуулахдаа дараахь зарчмыг баримтална: /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 5.3.9.а. сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төрийн бодлого, эрчим хүчний нэгдсэн сүлжээний тогтвортой ажиллагаатай уялдуулан төсөл хэрэгжих байршил, эх үүсгүүрийн төрөл, хүчин чадал, жилд худалдаж авах эрчим хүчний хэмжээг урьдчилан тодорхойлсон байх;
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – ▪ Практикт нийцэж байгаа байдал –Бусад үр дагавар
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Сэргээгдэх эрчим хүчний салбарын төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, тодорхойлох зохицуулалт зөв зүйтэй, оновчтой хуульчлагдсан эсэх? 2. Сэргээгдэх эрчим хүчний салбарын бодлого тодорхойлолт болон түүний хэрэгжилт хангалттай сайн үр дүнтэй байгаа эсэх?
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	Сэргээгдэх эрчим хүчний салбарын бодлогын бичиг баримтууд, түүний хэрэгжилттэй холбоотой эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл

Үнэлсэн байдал

1. Сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Эрчим хүчний яам боловсруулж, Улсын Их Хурал тодорхойлох буюу батлах, баталсан бодлогыг Эрчим хүчний яам хэрэгжүүлдэг. Харин бодлогын хэрэгжилтийн асуудлыг бүхэлд нь хариуцах ёстой Засгийн газарт энэхүү эрх хэмжээг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар олгоогүй байх бөгөөд зөвхөн бие даасан эх үүсгүүрээр хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангах сумдын жагсаалтыг батлахаар хуульчилсан байна.

Засгийн газар зөвхөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн асуудал, тэр дундаа бие даасан эх үүсгүүрүүдийг хаана, хаана ямар байршилд барих шаардлагатайг тогтоох асуудлыг л шийдвэрлэхээр заасан байна. Бие даасснаас бусад эх үүсгүүрүүд

буюу дамжуулах сүлжээнд холбогдох эх үүсгүүрүүдийг хаана, ямар хүчин чадалтайгаар барих шаардлагатайг тодорхойлох бодлогыг асуудлыг хэн хэрхэн тогтоох талаар тухайлан нарийвчилж заагаагүй байна. Гэсэн хэдий ч тус хуулийн 5.3.1 дахь заалтад “сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх”, 5.3.9.а. дахь заалтад “сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төрийн бодлого, эрчим хүчний нэгдсэн сүлжээний тогтвортой ажиллагаатай уялдуулан төсөл хэрэгжих байршил, эх үүсгүүрийн төрөл, хүчин чадал, жилд худалдаж авах эрчим хүчний хэмжээг урьдчилан тодорхойлсон байх” гэсэн Эрчим хүчний яамны эрх хэмжээнээс дүгнэхэд Эрчим хүчний яам тухайн асуудлыг өөрийн энэхүү чиг үүргийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байна хэмээн үзэж болохоор байна. Гэвч энэхүү асуудлыг хуульд цаашид нарийвчлан зохицуулж, иймэрхүү тодорхойгүй байдлыг арилгах хэрэгцээ, шаардлагатай байна гэж дүгнэхээр байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтын дагуу “сэргээгдэх эрчим хүчний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах.” гэж Эрчим хүчний яаманд эрх хэмжээ олгосон ч тухайн заалтын дагуу салбарын боловсон хүчний бодлогыг боловсруулж батлуулаагүй байгаа нь тухайн заалтын хэрэгжилт хангалтгүй, зорилгодоо хүрээгүй, практикт нийцээгүй, салбарын боловсон хүчний бодлогыг асуудал орхигдсон гэсэн бодит сөрөг үр дагаврыг бий болгосон байна гэж дүгнэхээр байна.

2. Сэргээгдэх эрчим хүчний бодлого тодорхойлолтын хүрээнд доорх хүснэгтэд заагдсан бодлогын бичиг баримтууд батлагдан гарсан байна.

	2000-2015 он
	Монголын эрчим хүчний салбарын 2000–2020 оны мастер төлөвлөгөө Эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратеги, 2002 он Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, 2002 он, 2007 он Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2005 – 2020 он Монголын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, 2007 – 2040 он, Түлш эрчим хүчний салбарын 2008 – 2015 оны төрийн бодлого Эрчим хүчний хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2015-2030 он 100 000 нарны гэр" үндэсний хөтөлбөр, 1999 - 2012 он
	2015-2020 он
	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, 2015-2030 он Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2005 он Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, 2017 он
	2020 оноос хойш
	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 он Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай, 2021 он Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2020 он Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2024 он Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод

2041– 2050 онуудад эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.

2031– 2040 онуудад гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлж, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2041– 2050 онуудад ногоон эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж бүс нутагтаа эрчим хүчийг тогтвортой нийлүүлнэ хэмээн тус тус зааж Монгол Улс урт хугацаандаа сэргээдэх эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг тодорхойлсон байна.

Бодлогын баримт бичгийн системчлэлийн дагуу бодлогын баримт бичгүүд батлагдсан байдлыг доорх схемээр харуулав.



“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт улсын хөгжлийн бодлогыг 10 жилийн үечлэлтэй 3 хэсэгт хувааж тодорхойлсон ба эрчим хүчний салбарын 2020-2030 оны хөгжлийн зорилтыг “Эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээр хангах”, “Хүлэмжийн хийг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” гэж томьёолж, түүнд үндэслэн Шинэ сэргэлтийн бодлого дунд хугацааны баримт бичгийг баталсан байна.

Шинэ сэргэлтийн бодлогоор өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахад нийт 2660МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөлийг төлөвлөсөн. Мөн салбарын санхүү эдийн засгийн бие даасан байдлын хангах зорилтын хүрээнд эрчим хүчний үнэ тарифыг улирал тутам индексжүүлэх заалтыг тусгасан байна.



Улсын хөгжлийн 10 жилийн төлөвлөгөө(Шинэ сэргэлтийн бодлого)-д үндэслэн Монгол улсыг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэл батлагдсан бөгөөд нийт 874МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөлийг төлөвлөсөн.



Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлтэй уялдаатай төлөвлөгдөх ёстой Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг “Эрчим хүчний шинэчлэл” гэж тодорхойлон нийт 3930МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөл, 2000МВт хүчин чадалтай нар, салхины эрчим хүчний парк байгуулахаар төлөвлөсөн. Яриа хэлэлцээр, таамаглалын түвшинд байгаа, засаглалын 4 жилийн хугацаанд бодитой хэрэгжих магадлал нь тодорхойгүй, системийн бодит эрэлтээс давсан хүчин чадлыг төлөвлөсөн байна.



Улсын Их Хурлын 2005 оны 32 дүгээр тогтоолоор “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийг баталж байсан боловч 2015 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон. Хөтөлбөрийн Дөрвийн 2 дахь хэсэгт “Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг шат дараатай хэрэгжүүлснээр 2010 он гэхэд улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 3-5 хувийг, 2020 он гэхэд 20-25 хувийг сэргээгдэх эрчим хүч ашиглан үйлдвэрлэнэ.” гэсэн зорилт тавьж байсан байна.

Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор батлагдаж байсан боловч 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон "Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого"-д сэргээгдэх эрчим хүчний бодлогыг ийнхүү зааж байсан байна:

Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

3.1.6.сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.

3.2.2.3.Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах;

3.2.6.стратегийн зургадугаар зорилго буюу сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүрээнд:

3.2.6.1.Монгол орны сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус, газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний нөөцийг нарийвчлан тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэ техник, технологийн судалгаа, шинжилгээ хийх байгууллагыг хөгжүүлэх;

3.2.6.2.эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх;

3.2.6.3.сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг бий болгох;

3.2.6.4.айл өрх, аж ахуйн нэгж, алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглах, илүүдэл эрчим хүчээ сүлжээнд нийлүүлэхийг дэмжих;

3.2.6.5.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах;

3.2.6.6.байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах.

4.1.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат /2015-2023 он/: түлш, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурийг бий болгох, эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах үе.

4.1.1.Нэгдүгээр үе шатанд хүрэх үр дүн: Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, үр ашиг өндөртэй өндөр параметрийн тоноглолыг ашиглаж эхлэх бөгөөд нийт суурилагдсан чадлын 10-аас доошгүй хувийг усны эх үүсвэрээр бүрдүүлж, нөөц чадлыг 10 хувьд хүргэн, сэргээгдэх эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Бодит үнэ тарифын тогтолцоог бий болгож, эрчим хүчний салбарыг эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёрдугаар үе шат /2024-2030 он/: Цахилгаан эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчийг тогтвортой хөгжүүлэх үе.

4.1.2.Хоёрдугаар үе шатанд хүрэх үр дүн: Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн аюулгүйн нөөцийг 20-оос доошгүй хувьд хүргэж, нийт суурилагдсан чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ 30 хувьд хүрнэ. Бүсүүдийг өндөр хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугамаар холбож, мэдээллийн хяналт удирдлагыг цогц систем бүхий эрчим хүчний нэгдсэн ухаалаг системийг бий болгоно. Түгээх, хангах сүлжээг бүрэн хувьчилж, эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөний зарчмаар ажиллуулна. Хөрш орнуудтай их чадлын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамаар холбогдож цахилгаан эрчим хүч экспортлох үе. Үүнд:

4.1.2.1.Монгол Улсыг бүхэлд нь хамарсан эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдсан байх;

4.1.2.2.Сэлэнгэ мөрний ай савд том чадлын усан цахилгаан станц, өмнөд бүсэд нийт 300 МВт чадалтай салхин парк, нарны станцууд, экспортын зориулалтын том чадлын цахилгаан станц, дамжуулах шугам баригдсан байх;

4.1.2.3.эрчим хүчний чанар, тасралтгүй найдвартай хангамж хөгжингүй орнуудын жишигт хүрэх;

4.1.2.4.Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний худалдаанд идэвхтэй оролцогч орнуудын нэг болсон байх;

4.1.2.5.инноваци, өндөр технологийн чиглэлээр эрчим хүчний үндэсний судалгааны тогтолцоо бий болсон байна;

4.1.2.6.эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал, нийт үйлдвэрлэлд хувийн хэвшлийн оролцоо давамгайлсан байх;

4.1.2.7.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны үйлдвэрлэлийн автоматжуулалт, мэдээллийн хяналт удирдлагыг цогц системд бүрэн шилжүүлж, нэгдсэн ухаалаг сүлжээтэй болсон байх.

4.2.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2014 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ:

Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоон хэмжээ		
	2014 он /суурь он/	Нэгдүгээр үе шат /2023 оны түвшинд/	Хоёрдугаар үе шат /2030 оны түвшинд/
Цахилгаан үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадлын нөөц	-10%	10%-иас багагүй	20%-иас багагүй
Томоохон хотуудын дулааны эх үүсвэрийн чадлын нөөц	3%	10%-иас багагүй	15%-иас багагүй
Төвийн бүсийн цахилгааны үнийн бүтцэд ногдох ашгийн хэмжээ	-16.22%	0%	5%

Дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээ	14.4%	11.2%	9.14%
Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал /Оюутолгойн импорт ороогүй/	13.7%	10.8%	7.8%
Дотоодын хэрэгцээний нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ	7.62%	20%	30%
1 Гкал эрчим хүч үйлдвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээ	0.52 тонн CO_2 эквивалент	0.49 тонн CO_2 эквивалент	0.47 тонн CO_2 эквивалент
Барилгын дулааны алдагдлыг бууруулах хэмжээ	0%	20%	40%
Эрчим хүчний үйлдвэрлэлд нэвтэрсэн байх технологийн дэвшил	Өндөр даралтат технологи	Саб критикал даралтат технологи, Байгалийн хийг ашиглах, Их чадлын цэнэг хураагуурын систем, ус хуримтлуурын станц	Супер критикал, хэт супер критикал даралтат технологи, Устөрөгч ашиглах, Нарны илчийг ашиглах технологи

Ийнхүү бодлогын бичиг баримтуудад сэргээгдэх эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг тодорхойлж 2024 гэхэд нийт суурилагдсан хүчин чадлын 20-25 хувьд хүрч сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх зорилтууд тавьсан байх боловч өнөөдрийн байдлаар сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр үйлдвэрлэгдсэн эрчим хүчний хэмжээ нийт хүчин чадлын хэмжээний 16 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байгааг доорх хүснэгтээс харж болно. Энэ нь дээрх бодлогын баримт бичгүүд, хөтөлбөрүүдийн дагуу зорьж байсан хэмжээндээ арай хүрч чадаагүйг харуулж байна.

Иймд тухайн бодлогын хэрэгжилтийн зорилгодоо хүрсэн түвшин нь 64 хувьтай байна гэж дүгнэхээр байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны дугаар сарын . . . ны өдрийн . . . . . дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

Эх үүсвэрүүдийн цахилгааны суурилагдсан хүчин чадал, түүний өөрчлөлт

ЦЭХ-ний суурилагдсан хүчин чадал (МВт)

Бүс	Эх үүсвэрийн нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ТБНС	ДЦС-2	24	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0
	ДЦС-3	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0
	ДЦС-4	683.0	683.0	683.0	683.0	683.0	772.0	772.0	772.0	772.0	772.0
	ДДЦС	48.0	48.0	48.0	48.0	83.0	83.0	83.0	83.0	83.0	83.0
	ЭДЦС	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	71.0	71.0	71.0	71.0
	Ухаахудаг ДЦС	18	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0
	ДалДЦС	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
	Эрдэнэт үйлдвэр ХХК	5.0	5.0	5.0	53.0	53.0	53.0	53.0	53.0	53.0	53.0
	Монцемент билдинг ХХК	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0
	ДБЭХС	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	86.0
	ДЦС-ын дүн	**1062.0**	**1,026.0**	**1,026.0**	**1,074.0**	**1,109.0**	**1,198.0**	**1,233.0**	**1,233.0**	**1,233.0**	**1,319.0**
	Импорт										
	Салхит СЦС		50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
	Сайншанд СЦС				55.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	55.0
	Цэций			50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
	СЦС-ын дүн		**50.0**	**100.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**
	Дархан НС			10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Эвридэй ферм НС			10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Нарантээг НЦС				15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0
	Тэнүүнгэрэл НЦС					15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0
	Сүмбэр НЦС					10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Дезерт солар вуан ХХК НЦС						30.0	30.0	30.0	30.0	30.0
	Солар повер монголиа ХХК НЦС										15.0
	НЦС-ын дүн		**0.0**	**20.0**	**35.0**	**60.0**	**90.0**	**90.0**	**90.0**	**90.0**	**105.0**
	ТБНС-ний нийт дүн		**1,076.0**	**1,146.0**	**1,264.0**	**1,324.0**	**1,443.0**	**1,478.0**	**1,478.0**	**1,478.0**	**1,579.0**
	ТБНС-ний СЭХ-ний нийт дүн		**50.0**	**120.0**	**190.0**	**215.0**	**245.0**	**245.0**	**245.0**	**245.0**	**260.0**
	ТБНС-ний СЭХ-ний эзлэх хувь		**5%**	**10%**	**15%**	**16%**	**17%**	**17%**	**17%**	**17%**	**16%**

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн үзэл баримтлалын нэгэн томоохон асуудал бол алслагдмал, төвийн нэгдсэн сүлжээнд холбоход зардал өндөртэй суурин газруудыг сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүрээр эрчим хүчээр хангах тухай асуудал байсан байна. Засгийн газар энэ төрлийн эх үүсгүүрийг барих бодлогыг асуудлыг шийдвэрлэхээр тус хуулийн 5.2-т заасан байгаа хэдий ч ийм эх үүсгүүрийн тусгай зөвшөөрллийн олголт огт хийгдээгүй, ийм төрлийн төсөл огт хэрэгжээгүй, Эрчим хүчний зохицуулах хорооноос бие даасан үүсгүүрийн үйлдвэрлэсэн эрчим хүчний үнэ, тариф гэж мөн баталж байгаагүй байна.[1] Иймд тус хуулийн 5.2 дахь хэсэг болон бие даасан эх үүсгүүрийн талаар зохицуулсан бусад заалтууд болох 4.1.5, 5.1, 5.2, 5.5.4, 7.3-7.6 дахь хэсгийн заалтуудыг зохицуулалтын зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй, эх үүсвэрийн дутагдлыг арилгаж чадаагүй, сэргээгдэх эрчим хүчний бодлогын зорилтдоо бүрэн хүрч чадаагүй гэсэн сөрөг үр дагварт хүргэсэн гэж дүгнэхээр байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх

[1] Эрчим хүчний зохицуулах хороо, 2024 он

хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг уялдуулан батлах;” гэж заасан тул энэхүү хууль батлагдсантай холбоотойгоор үүнээс өмнө батлагдан гарсан салбарын бодлогын бичиг баримтуудыг хүчингүй болсонд тооцсон бөгөөд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заагдсан хөгжлийн бодлогын бичиг баримтуудыг баталж гаргасан байна.

Тухайн хөгжлийн бодлогын баримт бичигт өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэглээг хангахад чиглэсэн бодлого, төсөл арга хэмжээний төлөвлөлтүүд түлхүү туссан байх бөгөөд салбарын үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан нэгдмэл бодлого тодорхойлогдсон гэж дүгнэхэд учир дутагдалтай байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн бодлого гэдгийг дараах байдлаар томьёолсон байна.

4.1.1."хөгжлийн бодлого" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс батлагдсан баримт бичгийг;

Дээрх заалт нь салбарын түвшинд хөгжлийн бодлогын баримт бичигтэй байх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд хүний нөөц, аюулгүй байдал, техник, технологи, зах зээл, санхүү, эдийн засаг, засаглал, менежмент, хувьчлал, хөрөнгө оруулалт зэрэг олон чиглэлд салбарын хэмжээнд баримтлах бодлого, хөгжлийн төлөвлөлтүүд хийгдэх шаардлагатай гэдгийг хуульчилсан заалт байна.

Гэвч эдгээр бичиг баримтууд нь дээрх хуулийн заалтын шаардлагыг хангасан, нэгдсэн, цогц, уялдаа холбоо бүхий сэргээгдэх эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж чадсан гэж дүгнэх боломжгүй байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 3: ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Хуулийн заалт	**6 дугаар зүйл.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих** 6.1.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих хуулийн этгээд нь Эрчим хүчний тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авна. 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч байж болно. **7 дугаар зүйл.Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл** 7.1.Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх хуулийн этгээд нь Эрчим хүчний тухай хуулийн 13.1-д заасан цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авна. 7.2.Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгч дараахь эрх, үүрэгтэй: 7.2.1.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрт хамгийн ойр орших дамжуулах сүлжээний холбох цэгт цахилгаан эрчим хүч нийлүүлэх; 7.2.2.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс дамжуулах сүлжээний холбох цэг хүртэлх цахилгаан дамжуулах зардлыг хариуцах; 7.2.3.диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тавьсан шаардлагыг биелүүлэх. 7.3.Бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч дараахь эрх, үүрэгтэй: 7.3.1.үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд баталгаат тоолуураар нийлүүлэх; 7.3.2.тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн хэрэглэгчдэд худалдсан цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг Засгийн газраас нөхөн авах. */Энэ заалтад 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 7.4.Энэ хуулийн 11.2 дахь хэсэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр эрчим хүч үйлдвэрлэгчид хамаарахгүй. */Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

	7.5.Бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч нь эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. 7.6.Бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч нь эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байж болно. **8 дугаар зүйл.Диспетчерийн үндэсний төвийн үүрэг** */Энэ зүйлийн гарчигт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 8.1. Диспетчерийн үндэсний төв дараахь үүрэгтэй: */Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 8.1.1.үйлдвэрлэгчээс нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу батлагдсан тарифаар худалдан авах; 8.1.2. үйлдвэрлэгчээс нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг эрчим хүчний дамжуулах сүлжээний хуваарилах байгууламжид техникийн шаардлагын дагуу холбохоос бусад өргөтгөл хийх, түүний зардлыг хариуцах. */Энэ заалтад 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* **9 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл авах** 9.1.Сонирхогч хуулийн этгээд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих, буюу үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд гаргана. */Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 9.2.Энэ хуулийн 9.1-д заасан хүсэлтэд Эрчим хүчний тухай хуулийн 21.2-т зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргана: 9.2.1.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах зориулалтаар олгосон газрыг эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай

	тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; */Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 9.2.2.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрт ашиглагдаж хугацаа нь дууссан зай хураагуурыг дахин боловсруулах, устгах төлөвлөгөө; 9.2.3.усны эрчмийг ашиглах барилга байгууламж барих бол газрын хөрс, ургамал, геологи, гидрогеологийн нөхцөл, газар зүйн байрлал, газрын гадаргуу, уур амьсгал, агаарын даралт, салхины горим болон ус зүйн судалгааны материал; 9.2.4.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн техник, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь олон улсын болон үндэсний стандартыг хангаж байгаа тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт. 9.3.Тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэгтэй холбогдсон харилцааг Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу зохицуулна.
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – ▪ Практикт нийцэж байгаа байдал – ▪ Бусад үр дагавар
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтууд нь зөв зүйтэй, оновчтой хуульчлагдсан эсэх, хуулийн хэрэгцээ, шаардлагадаа нийцэж байгаа эсэх, бодит байдалд нийцэж байгаа эсэх, зайлшгүй зохицуулах харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэгжүүлэхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарч байгаа эсэх? 2.Тусгай зөвшөөрөл олголттой холбоотой заалтууд зохицуулалтын зорилгодоо хүрсэн эсэх?
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	

Үнэлсэн байдал

1. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих болон үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах тухай хуульчилсан байх бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн дагуу авахаар заасан байна.

Эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний барилга байгууламж барих 2 төрлийн тусгай зөвшөөрөл байна. Нэгдүгээрт, Эрчим хүчний тухай хуулийн 20 дугаар зүйлд эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл талаар заасан ба энэ нь ийм төрлийн барилга байгууламжийг барих хүсэлт гаргасан хуулийн этгээд буюу төсөл хэрэгжүүлэгч захиалагч талд олгох тусгай зөвшөөрөл юм. Хоёрдугаарт, Эрчим хүчний тухай хуулийн 20^1 дүгээр зүйлд эрчим хүчний барилга байгууламжийн барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл буюу төслийн гүйцэтгэгч талд өгөх тусгай зөвшөөрлийг хуульчилсан байна.

Гэтэл Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд энэ хоёр төрлийн зөвхөн эхнийх нь төрлийн тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай тухай тус хуулийн 6 дугаар зүйлд заасан байна. Харин сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг ажил гүйцэтгэгчийн тусламжтайгаар барьж байгуулах тохиолдолд Эрчим хүчний тухай хуулийн 20^1 дүгээр зүйлд заагдсан эрчим хүчний барилга байгууламжийн барилга угсралтын ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр ажлаа гүйцэтгүүлж болох эсэх нь тодорхойгүй байна.

Эрчим хчүний тухай хуулийн 20^1 дүгээр зүйлд “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21, 14.22 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 21.1-д заасан шаардлага хангасан хуулийн этгээдэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.” гэж заасан бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн тухайн заалтуудад сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн төрөл гэж тусгайлан заасан заалт байхгүй байна.

Эрчим хүчний салбар (сэргээгдэх эрчим хүчийг оролцуулаад)-ын харилцаа нь төрөөс зохицуулалттай захиргааны эрх зүйн ангилалд ордог. Нийтийн эрх зүйн харилцаанд хуульд зааснаас бусад нь хориотой зарчим үйлчилдэг тул Эрчим хүчний тухай хуульд зөвхөн заагдсан буюу Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд заагдаагүй тусгай зөвшөөрлөөр тус хуулийн харилцаанд оролцох нь хориотой гэсэн үг юм. Хэдийгээр Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль тогтоомж нь Эрчим хүчний тухай хууль, ...-с бүрдэнэ” гэж заасан хэдий ч тусгай зөвшөөрлийн харилцаа нь тухайн ажлын техникийн онцлогт тохируулан тусгай мэргэжил, боловсрол, ур чадвар шаардаж байгааг зохицуулж байдаг тул цаашид Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд энэ асуудлыг тодорхой болгож хуульчилж зааж өгөх шаардлагатай байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйл болон Эрчим хүчний тухай хуулийн 20 дугаар зүйлд заагдсан эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл нь төсөл хэрэгжүүлэгч буюу захиалагч талд олгогдог тул үүнийг “тусгай

зөвшөөрөл” бус “зөвшөөрөл” болгож өөрчлөх нь илүү оновчтой юм. Учир нь тусгай зөвшөөрлийн ойлголт нь аливаа нарийн мэргэжлийг үйл ажиллагааг эрхлэхэд тавигддаг мэргэжлийн болон техникийн хүчин чадлыг хангасан эсэхийг илэрхийлдэг лицензийн ойлголт юм, харин барилга байгууламж барих зөвшөөрлийн ойлголт нь тодорхой байршилд, тодорхой хүчин чадал бүхий төсөл хэрэгжүүлэхийг төрөөс зөвшөөрч байгаа лицензийн шинж чанаргүй, тодорхой фактыг зөвшөөрч байгаа нэг удаагийн шинжтэй шийдвэр гаргалт тул тусгай зөвшөөрөл хэмээн хуульчлах нь зохицуулалтын алдаатай, хууль, эрх зүйн сөрөг үр дагавар үүсгэх зохицуулалт болсон байгааг цаашид Эрчим хүчний тухай хууль болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиудад “эрчим хүчний барилга байгууламж барих зөвшөөрөл”-ийн харилцаа болгож өөрчлөх шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгч ба бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч гэж хоёр төрлийн үйлдвэрлэгч байхаар хуульчилсан байна. Эхний төрлийн үйлдвэрлэгчийн тусгай зөвшөөрөл олголтын талаар энэхүү үнэлгээний хүрээний 3.2 дахь хэсэгт нарийвчлан үнэлэлт хийсэн. Харин хоёр дахь төрөл болох бие даасан үүсгүүрийн тусгай зөвшөөрлийн олголт нь 2007 оноос хойш өнөөдрийг хүртэл 17 жилийн хугацаанд нэг ч хийгдээгүй байна.[2] Иймд бие даасан үүсгүүрийн тусгай зөвшөөрлийн талаарх Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 – 7.6 дахь хэсгийн заалтуудын зохицуулалтын зорилгодоо хүрч чадаагүй, бодит байдалтай нийцээгүй буюу хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй, хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүссэн гэж дүгнэхээр байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7.2.2 дахь заалтад дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгч үүсгүүрээс дамжуулах сүлжээний холбох цэг хүртэлх цахилгаан дамжуулах зардлыг хариуцах гэсэн нь тодорхой биш, нэг мөр ойлгогдохоор заалт биш байна. Дамжуулах зардал гэж дамжуулалтын алдагдал, дамжуулах сүлжээний урсгал засварын зардал хэлж байгаа эсэх, эсхүл дамжуулах сүлжээтэй холбох шинээр цахилгаан дамжуулах ашиглалтын шугам, дамжуулах сүлжээний дэд станцад өргөтгөл хийх ажлыг хэлж байгаа эсэх нь тодорхой биш байгаа тул цаашид ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай байна.

Тус хуулийн 7.2.3 дахь заалтад “диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тавьсан шаардлагыг биелүүлэх.” гэж заасны “тавьсан шаардлагыг биелүүлэх” гэсэн нь хэт ерөнхий заалт байх бөгөөд ДҮТ-д хэт их эрх мэдлийг олгосон, тухайн байгууллагын зүгээс хууль тогтоомжид заагаагүй нэмэлт шаардлагыг ямар нэгэн үндэслэл, шалгуур үзүүлэлтгүйгээр тавих нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт хуулиар урьдчилан таамаглах боломжгүй дарамт учруулах, эрх ашгийг нь хөндөх нөхцөл болж байна. Жишээ нь, ДҮТ-ээс нар, салхины эрчим хүчний үүсгүүр дээр батерей хургаагуур тавих

[2] Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлэл, 2024 он

шаардлага тавьж байгаа нь хууль тогтоомжид байхгүй шаардлагыг тавьж байгаагийн нэг тод жишээ болж байна.[3]

Иймд энэхүү тодорхой биш, эрх бүхий этгээдэд хэт их эрх мэдэл олгосон, өөрийн үзэмжээр асуудал шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн заалтыг засаж, сайжруулан тухайн эрх бүхий этгээдийн хуулиар хүлээсэн эрх үүргийг нарийн, тодорхой хуульчлах хэрэгцээ, шаардлагатай байна.

Түүнчлэн тус заалтын дагуу диспетчерийн зохицуулалтай холбоотойгоор үйлдвэрлэгчээс дутуу нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний маргаан их гардаг нь цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд диспетчерийн кохицуулалтын улмаас худалдах эрчим хүчинд хязгаарлалт тогтоосон бол тухайн дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийг төлөх тухай заадаг байсан бөгөөд үүний улмаас улс их хэмжээний өрөнд орох нөхцөл бүрддэг байсан байна. Иймд энэ төрлийн зохицуулалтыг одоогоор гэрээний нөхцөлд оруулахаа больсон байна. Цаашид ийм зарчмын болон бодлогын шинжтэй асуудлыг хуульд нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Тус хуулийн 7.6-д бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч нь эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байж болно гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.18 дахь заалтын нэгэн адил заасан нь эрх бүхий байгууллагаас үнэ, тариф тогтоохгүйгээр зах зээлийн зарчмаар эрчим хүч үйлдвэрлэгч үнээ тогтоох боломжийг олгосон заалт буюу зах зээлийн өрсөлдөөнт зах зээлийг бий болгох боломжийн нээсэн оролдлого юм. Гэвч энэхүү заалт нь биеэ даасан үүсгүүр одоогоор ашиглалтад ороогүй байгаатай холбогдуулан огт хэрэгжээгүй заалт юм. Иймд энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй, зохицуулалтын зорилгодоо хүрээгүй гэж дүгнэхээр байна.

Тус хуулийн 8.1.2 дахь заалтыг илүү тодорхой болгох шаардлагатай, учир нь энэ заалтын дагуу дамжуулах сүлжээнд холбох өргөтгөл хийх ажлыг хариуцахгүй гэж ойлгогдож байгаа бөгөөд үүнээс өөр өргөтгөл хийх гэдэг нь холбоо мэдээллийн тоноглол, системийн автоматик г.м. ямар асуудалд хамааруулах нь тодорхойгүй байгаа юм.

Тус хуулийн 9.1 дэх хэсэгт Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлд хандан тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргана гэсэн нь ямар тохиолдолд хороонд хандах, ямар тохиолдолд зөвлөлд хандах нь тодорхой бус байна. Үүнийг тодорхой хуульчлах шаардлагатай.

2. Эрчим хүчний зохицуулах хорооноос 2014 – 2024 оны хооронд нийт 64 төсөлд эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосон байгаагийн 48 нь сэргээгдэх эрчим хүчний төслүүд байна. Эдгээр бүгд дээр дурдсанчлан дамжуулах сүлжээнд холбогдох

[3] Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, 2024 он

үүсгүүр бүхий үйлдвэрлэгчид байна. Үүсгүүрийн төрөл, хүчин чадал г.м. нарийвчилсан мэдээллийг доорх хүснэгтээс харж болно.

Ангилал	Тусгай зөвшөөрөл авсан		Сүлжээнд холбосон	
	Төслийн тоо	Хүчин чадал	Төслийн тоо	Хүчин чадал
Усан цахилгаан станц	7	338	-	-
Салхин цахилгаан станц	3	155	2	105
Нарны цахилгаан станц	31	627	7	105
Био масс цахилгаан станц	3	61.4	-	-
Эрчим хүч хуримтлуурын станц	4	115	-	-
Сэргээгдэх дүн	48	1296	9	210
Уламжлалт эх үүсвэр	12	4300		
Бусад сүлжээнд нийлүүлэх	2	80	1	50
Экспортлох зориулалттай	2	9240		
НИЙТ ДҮН	**64**	**14916**	**10**	**260**

2014 оноос хойш олгогдсон бүх тусгай зөвшөөрлийг усан, салхин, нарны, хуримтлалуурын, биомассын зэрэг төрлүүдэд нийт хэдэн тусгай зөвшөөрөл олгогдсон, хэд нь ашиглалтанд орсон, хэд нь хүчингүй болсон, хэд тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан г.м. мэдээллийг доорх хүснэгтээс дэлгэрэнгүй харж болно.[4]

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	СХЧ */MBm/*	Тусгай зөвшөөрөл олгосон хугацаа	Ашиглалтад орсон эсэх	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа
Сэргээгдэх					
1. **Усан цахилгаан станц**					
1	Чаргайт УЦС ХХК	24.6	2017.09.12	Ашиглалтад ороогүй.	2025.09.12
2	Усны эрчим ХХК	18	2019.06.05	Ашиглалтад ороогүй.	2027.06.05
3	Жесика энержи ХХК	10	2019.07.04	Ашиглалтад ороогүй.	2027.07.04

[4] Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төвийн мэдээлэл, 2024 он.

4	Эрдэнэс пауер ХХК	45	2019.09.19	Ашиглалтад ороогүй.	2027.09.19
5	Эрдэнэбүрэнгийн УЦС ТБАГ	90	2020.01.23	Ашиглалтад ороогүй.	2025.01.23
6	Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц ХХК	100	2014.06.20	Ашиглалтад ороогүй.	2019.06.20
7	Эрдэнэт усан цэнэгт цахилгаан станц ХХК	50	2024.05.31	Ашиглалтад ороогүй.	2026.05.31
УЦС нийт		**337.6**			
2. Салхин цахилгаан станц					
1	Ти Би Эф энержи зуун ХХК	50	2015.07.07	Ашиглалтад ороогүй.	2025.10.31
2	“Клин энержи ази” ХХК	50	2014.09.30	2017.06.14	2027.06.14
3	“Сайншанд салхин парк” ХХК	55	2019.01.17	2019.01.17	2023.11.21
СЦС нийт		**155**			
3. Эрчим хүч хуримтлуурын станц					
1	Энержи сторежи ХХК	50	2017.09.21	Ашиглалтад ороогүй.	2024.09.21
2	Мөнх энержи сторежи ХХК	5	2019.11.07	Ашиглалтад ороогүй.	2024.11.07
3	Том нар энержи ХХК	10	2022.09.29	Ашиглалтад ороогүй.	2025.09.29

4	Кэй Жи Ай Эн ХХК	50	2022.12.01	Ашиглалтад ороогүй.	2025.12.01
ХС нийт		**115**			
4. Биомасс цахилгаан станц					
1	Эрэл ХХК	32	2015.02.26	Ашиглалтад ороогүй.	2023.02.26
2	Кэй эм инфра корпораци ХХК	15.4	2022.03.31	Ашиглалтад ороогүй.	2025.03.31
3	Нааново грин энержи Монголиа ХХК	14	2022.04.21	Ашиглалтад ороогүй.	2025.09.29
БиоЦС нийт		**61.4**			
5. Нарны цахилгаан станц					
1	“Соларповер интернэйшнл” ХХК	10	**2015.07.07**	2017.01.01	2027.01.01
2	“Эвридэй ферм” ХХК	10	2016.01.07	2017.08.31	2027.08.31
3	“Нарантээг” ХХК	15	2016.01.10	2018.11.22	2028.11.22
4	“И Эс Би солар энержи” ХХК	10	2016.04.21	2019.03.28	2029.03.28
5	“Тэнүүнгэрэл констракшн” ХХК	15	2016.06.10	2019.07.04	2029.07.04
6	“Дезерт солар пауэр вуан” ХХК	30	2015.01.08	2020.10.16	2025.10.16
7	“Солар повер монголиа” ХХК	15	2017.08.16	2024.05.31	2024.12.31

8	"Мошеа эко энержи" ХХК	50	2016.05.05	Ашиглалтад ороогүй	2024.12.31
9	Сан Степпе ХХК	50	2016.06.02	Ашиглалтад ороогүй	2025.12.31
10	Люкстюм ХХК	9	2016.06.02	Ашиглалтад ороогүй	2024.12.31
11	Солар энержи чандмань ХХК	21	2017.05.23	Ашиглалтад ороогүй	2024.12.31
12	"Мон-Кореа инженеринг" ХХК	8	2015.07.07	Хүчингүй болсон	
13	"Дөргөнийн НЦС" ХХК	10	2015.11.20	Хүчингүй болсон	
14	"Термальмегаваттс" ХХК	10	2016.12.08	Хүчингүй болсон	
15	"Хөдөөгийн цахилгаан" ХХК	10	2018.02.14	Хүчингүй болсон	
16	"Интернэшнл аэропорт девелопмент прожект" ХХК	30	2017.09.28	Хүчингүй болсон	
17	"Хужирт солар" ХХК	20	2017.10.26	Хүчингүй болсон	
18	"Солар газ повер" ХХК	30	2017.11.03	Хүчингүй болсон	
19	"Юнисол девелопмент" ХХК	15	2017.08.16	Хүчингүй болсон	
20	"Цэгц хараа" ХХК	30	2017.09.21	Хүчингүй болсон	

21	"Мөрөн солар системс" ХХК	30	2017.10.26	Хүчингүй болсон	
22	"Эрчис ундарга" ХХК	30	2017.11.03	Хүчингүй болсон	
23	"Морегрийн" ХХК	50	2017.11.03	Хүчингүй болсон	
24	"Грийн энержи девелопмент" ХХК	30	2017.12.21	Хүчингүй болсон	
25	"Эм Эн Эм Ти" ХХК	20	2017.12.27	Хүчингүй болсон	
26	"Смарт" ХХК	20	2016.03.31	Хүчингүй болсон	
27	"Сэргэлэнгийн нарны цахилгаан станц" ХХК	50	2017.05.23	Хүчингүй болсон	
28	"Ньюком солар энержи" ХХК	24	2018.10.31	Хүчингүй болсон	
29	"Юни солар" ХХК	30	2017.02.23	Хүчингүй болсон	
30	"Санрөүд трейд" ХХК	30	2017.04.13	Хүчингүй болсон	
31	"ДСЦТС" ХК	20	2017.05.23	Хүчингүй болсон	
НЦС нийт		**627**			
НИЙТ		**1296**			

Сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрлийн олголт нийтдээ 1.3 орчим ГВт хүчин чадлын төслүүдэд олгогдсон байна. Гэвч үүнээс хэрэгжсэн нь 210МВт хүчин чадал бүхий 9 төсөл хэрэгжсэн байгаа нь нийт олгогдсон сэргээгдэх эрчим хүчний хүчин

чадлын 16.2 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрөл олгосон төслүүдээс барьж байгуулж, сүлжээнд хүчин чадал үүсгэсэн төсөл маш цөөхөн байна. Энэ нь тусгай зөвшөөрлийн олголт үндэслэл муутай байх магадлалтай байна, эсхүл өөр ямар хүчин зүйлийн улмаас тухайн тусгай зөвшөөрөл авсан төслүүд хэрэгжихгүй байгааг судалж шалтгааныг нь тогтоох, цаашид ийм эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Нөгөө талаас энэхүү асуудлын бас нэг сөрөг тал нь хэрэв тусгай зөвшөөрөл олгогдсон төслүүдийн хэрэгжилт сайн байсан бол эрчим хүчний нэгдсэн сүлжээнд тэдгээрийг нийлүүлж шингээх боломжгүй юм. Эрчим хүчний системийн ачааллын таац 2030 оны түвшинд 3.7ГВт буюу 1.9ГВт нэмэлт хүчин чадал шаардлагатай байхаар байна. Тусгай зөвшөөрөл авсан эх үүсвэрүүд 2030 оны түвшинд бүрэн залгагдвал асар их хэмжээний хүчин чадлын илүүдэл үүсч, систем бүрэн шингээх боломжгүй байхаар дүр зураг харагдаж байна. Иймд тусгай зөвшөөрлийг олголтыг нэгдсэн бодлогоор оновчтой тодорхойлох шаардлагатай байна. Тусгай зөвшөөрлийн энэхүү асуудлаар Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ тайланд нарийвчилсан үнэлгээний дүгнэлтүүд мөн хийгдсэн болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 4: СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСГҮҮРИЙН ТӨСӨЛ

4.1. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн төсөл	
Хуулийн заалт	4.1.10."төсөл шалгаруулалт" гэж эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг тогтоосон техникийн нөхцөл, нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үнийн саналаар өрсөлдүүлэн сонгон шалгаруулах ажиллагааг; /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 4.1.11."төсөл хэрэгжүүлэх баталгаа" гэж төсөлд оролцогч нь төслийг бүрэн биелүүлэхийг баталгаажуулж ирүүлсэн банкны баталгаа, банканд байршуулсан мөнгөн хөрөнгийг; /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 5.3.8.төсөл шалгаруулалтын журмыг боловсруулах, батлах; /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 5.3.9.төсөл шалгаруулалтыг зохион байгуулахдаа дараахь зарчмыг баримтална: /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 5.3.9.а. сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төрийн бодлого, эрчим хүчний нэгдсэн сүлжээний тогтвортой ажиллагаатай уялдуулан төсөл хэрэгжих байршил, эх үүсгүүрийн төрөл, хүчин чадал, жилд худалдаж авах эрчим хүчний хэмжээг урьдчилан тодорхойлсон байх; 5.3.9.б.сэргээгдэх эрчим хүчний техник, технологи, нэгдсэн сүлжээнд худалдах үнийн саналаар өрсөлдөхүйц байх; 5.3.9.в.ил тод, шударга, өрсөлдөх тэгш боломжтой байх. 5.5.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.5.2.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр байршуулах зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэх; 10.2. Энэ хуулийн 10.1-д заасан гэрээнд үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны чадал, чанарын үзүүлэлт, хэмжээ, тариф, хугацаа, төсөл хэрэгжүүлэх баталгаа, цахилгааны тоолуур, хэмжих хэрэгслийн байршил, түүний төрөл, загвар, нарийвчлал, итгэлцүүрийн хэмжээ, дугаар, цахилгааны төлбөр, тооцооны

	нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тусгана. /Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – хангалтгүй ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – хангалтгүй ▪ Практикт нийцэж байгаа байдал – хангалтгүй
Томьёолсон шалгуур үзүүлэлт	Дээрх хуулийн заалтууд нь зохицуулалтын зорилгодоо хүрсэн эсэх?
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	Төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулагдсан эсэх талаарх мэдээлэл

Үнэлсэн байдал

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль анх 2007 онд батлагдах үед сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барихдаа төсөл сонгон шалгаруулалтын хэлбэрээр барих тухай үзэл баримтлал, заалт байгаагүй бөгөөд энэ энэ асуудлыг 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 4.1.10, 4.1.11 дэх заалтууд болон 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 10.1-д заасан гэрээнд... төсөл хэрэгжүүлэх баталгаа... -г тусгана” гэж нэмж зааснаас дүгнэхэд шинээр баригдах сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төслийг зөвхөн сонгон шалгаруулалт явуулах замаар хэрэгжүүлж, төсөл хэрэгжүүлэгчтэй цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа төсөл хэрэгжүүлэх баталгааг заавал гэрээнд тусгахаар болсон байна.

Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төсөл сонгон шалгаруулахад баримтлах зарчмыг сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төрийн бодлого болон нэгдсэн сүлжээний тогтвортой ажиллагаатай уялдуулан шинэ эх үүсгүүрийн байршил, төрөл, хүчин чадал, худалдаж авах эрчим хүчний хэмжээг урьдчилан тодорхойлсон байх; техник, технологи, үнийн саналаар өрсөлдөхүйц байх; ил тод, шударга, өрсөлдөх тэгш боломжтой байх хэмээн 5.3.9 дэх заалтад тодорхойлсон нь зөв зүйтэй, оновчтой болсон байна.

Энэ нь төсөл сонгон шалгаруулалтын үйл явцад үзэмжээр шийдвэр гаргах, хэн нэгэнд бусдаас давуу байдал бий болгох, хэрэгцээ шаардлагад нийцээгүй төсөл сонгох

гэх зэрэг асуудлуудаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж чадсан байна. Төсөл сонгон шалгаруулалтын аргын давуу талуудаас дурдвал:

1. Өрсөлдөхүйц үнээр зардлыг бууруулах боломжтой: Дуудлага худалдаа нь хөгжүүлэгчдийн дунд өрсөлдөөнийг бий болгож, үнийг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн зардлын үр ашгийг баталгаажуулдаг. Сонгон шалгаруулалт нь бодит зардлыг тусгаж, мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний зах зээлийн үнийг тодорхой зааж өгдөг.

2. Хөрөнгө оруулалтын баталгаа: сонгон шалгаруулалтанд нь шалгарсан төсөл хэрэгжүүлэгч сэргээгдэх эрчим хүч худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ (PPA) байгуулж, түүгээрээ гэрээний үнэ тарифыг баталгаажуулж авах боломжтой байна.

3. Дутагдалтай байгаа эх үүсвэрийг хурдан хугацаанд өргөтгөх боломж: томоохон хэмжээний сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлыг сонгон шалгаруулалтын аргыг хэрэглэн хурдан хугацаанд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт татан бий болгох боломжтой байна.

4. Засгийн газраас нэгдсэн бодлого хэрэгжүүлэх боломж: төсөл сонгон шалгаруулалт нь бодлого боловсруулагчдад эрчим хүчний төлөвлөлтийн зорилгод нийцүүлэн төслийн хэмжээ, байршил, технологийг тодорхойлох боломжийг олгодог.

5. Инновацийг дэмжих: сонгон шалгаруулалтанд оролцогчдыг шинэ, дэвшилтэт техник технологи санал болгох, үүгээрээ дамжуулан зардлын хэмнэлт бий болгох боломжийг бий болгож болно.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд төсөл сонгон шалгаруулалтын арга хэрэглэх сул талууд нь:

1. Зах зээл дээр хүчийг төвлөрүүлэх: Том, туршлагатай хөгжүүлэгчид дуудлага худалдаанд давамгайлж, жижиг эсвэл дотоодын оролцогчдыг шахан гаргах магадлал бий болдог.

2. Төсөл хэрэгжүүлэх шат дараалал, цаг хугацааг нэмэх: сонгон шалгаруулалтанд бэлтгэх, ТЭЗҮ хийх, дуудлага худалдааны нарийн төвөгтэй дүрэм журамд шилжих нь оролцогчдод өндөр өртөгтэй, цаг хугацаа их шаардсан ажил болдог.

3. Нийгэм, эдийн засгийн асуудал: жижиг төсөл хэрэгжүүлэгч болон дотоодын оролцогч нарт дуудлага худалдаанд үр дүнтэй оролцох нөөц, туршлага дутмаг байж болно. Төсөл сонгон шалгаруулалт нь оновчтой нөөц бүхий бүс нутагт төслүүдийг төвлөрүүлснээрээ бусад байрлалд газарзүйн болон нийгмийн тэгш байдлын боломжийг хязгаарлаж болно.

Иймд төсөл сонгон шалгаруулалтын аргыг илүү үр дүнтэйгээр ашиглах, ирээдүйд бий болж болзошгүй сул талыг багасгахын тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн хуулийн зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна. Үүнд:

1. сонгон шалгаруулалтанд шалгарсан этгээд төсөл хэрэгжүүлэх амлалтандаа хүрэх уян хатан, сонголттой хэрэглэх хөшүүргийн нэмэлт механизм бий болгох жишээ нь, хуулийн 4.1.11-т заасан баталгаанаас гадна торгууль, алдангийг санкцыг бий болгох.

2. Бодлогын интеграци хийх: сонгон шалгаруулалтын аргыг татварын урамшуулал, инновацийн дэмжлэг зэрэг бусад бодлоготой хослуулах. Түүнчлэн, төсөл төлөвлөхдөө үндэсний эрчим хүч, цаг уурын зорилтуудтай нийцүүлэх.

3. Оролцогч талуудын оролцоог хангах: жижиг тоглогчдод оролцоход нь дэмжлэг үзүүлэх (жишээлбэл, техникийн сургалт, санхүүгийн тусламж үзүүлэх) төрөл бүрийн аргуудаас хэрэглэж олон талын оролцоог хангасан төсөл сонгон шалгаруулалтын тэгш эрх бүхий тогтолцоог бий болгох.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтын дагуу Эрчим хүчний сайдын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 100 дугаар тушаалын хавсралтаар “Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам”-ыг баталсан байна.

Ийнхүү төсөл сонгон шалгаруулах арга замаар сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсгүүрийн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч одоогоор ямар нэгэн сонгон шалгаруулалт зарлаагүй байгаа нь энэхүү асуудлыг зохицуулсан хуулийн заалтуудын зорилгодоо хүрсэн түвшин хангалтгүй, хэрэгжилт хангалтгүй, практикт нийцээгүй гэсэн үнэлгээний дүгнэлтэд хүргэж байна. Түүнчлэн, огт хэрэгжээгүй заалт тул хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг үнэлэх боломжгүй байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 5: ҮНЭ, ТАРИФ

Хуулийн заалт	4.1.9."дэмжих тариф" гэж сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг. /Энэ заалтыг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/ 5.6. Эрчим хүчний зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: /Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 5.6.1.дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний үнийн тооцоог хянаж, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу тарифыг батлах; 5.6.3. хэрэглэгчийн худалдан авах дэмжих тарифын хэмжээг тогтоох; */Энэ заалтыг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/* 5.6.4.цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний үйлчлэх хугацаа дууссаны дараа үнэ, тарифыг тухай бүр тогтоох. */Энэ заалтыг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ хэсгийн дугаарыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчилсөн/* 5.6.5.хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгааны түгээх сүлжээнд нийлүүлэх үнэ, тарифыг жил бүр хянаж, тогтоох. /Энэ заалтыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./ 8.1. Диспетчерийн үндэсний төв дараахь үүрэгтэй: /Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ 8.1.1.үйлдвэрлэгчээс нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу батлагдсан тарифаар худалдан авах; 10.2. Энэ хуулийн 10.1-д заасан гэрээнд үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны чадал, чанарын үзүүлэлт, хэмжээ, тариф, хугацаа, төсөл хэрэгжүүлэх баталгаа, цахилгааны тоолуур, хэмжих хэрэгслийн байршил, түүний төрөл, загвар, нарийвчлал, итгэлцүүрийн хэмжээ, дугаар, цахилгааны төлбөр, тооцооны нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тусгана. /Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

	11 дүгээр зүйл.Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тариф 11.1.Дамжуулах сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо дараахь хязгаарын хүрээнд тогтооно: */Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 11.1.1. салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.085 ам.доллар хүртэл; */Энэ заалтад 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 11.1.2.5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам.доллар; 11.1.3.нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.12 ам.доллар хүртэл. */Энэ заалтад 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгоно. */Энэ хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* ~~11.3. Бие даасан үүсгүүрээр үйлдвэрлэн нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл дараахь хязгаарын хүрээнд тогтооно:~~ ~~11.3.1. салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.10-0.15 ам. доллар;~~ ~~11.3.2. 500 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.08-0.10 ам. доллар;~~ ~~11.3.3. 501-2000 кВт хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.05-0.06 ам.доллар;~~

	~~11.3.4. 2001-5000 кВт хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.05 ам.доллар;~~ ~~11.3.5. нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.2-0.3 ам. доллар.~~ */Энэ хэсгийг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./* 11.4.Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэж, түгээх сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифыг тогтоохдоо дор дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ: */Энэ хэсэгт 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* */Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 11.4.1.тухайн бүс нутгийн газар зүйн байрлал, дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал; 11.4.2.үнэ, тариф нь хэрэглэгчдийн худалдан авах чадавхид нийцсэн байх. 11.5.Газрын гүний дулааны эрчим, биомасс болон энэ хуулийн 11.1-т зааснаас бусад сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний үнийг уг үнэ, тарифын нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзан эрчим хүчний зохицуулах хороо тогтооно. */Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 11.6.Эрчим хүчний системд холбогдох болон горим тохируулагч усан цахилгаан станцын үнэ, тарифыг бодит өртөг, техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан Эрчим хүчний зохицуулах хороо тогтооно. */Энэ хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/* 11.7.Энэ хуулийн 11.1-т заасан үнэ, тарифын хязгаарыг хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно.

	/Энэ хэсгийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/ */Энэ хэсэгт 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 11.8.Энэ хуулийн 11.1 дэх хэсэг цахилгаан экспортлох үйл ажиллагаанд хамаарахгүй. */Энэ хэсгийг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./* **12 дугаар зүйл.Үнэ, тарифын үйлчлэх хугацаа** Хэвлэх 12.1.Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө. */Энэ хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – хангалттай ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – хангалтгүй ▪ Практикт нийцэж байгаа байдал – хангалтгүй ▪ Бусад үр дагавар – эх үүсвэрийн дутагдлаас гарч чадаагүй сөрөг үр дагавар гарсан, мөн бие даасан үүсгүүрийн үзэл баримтлалаа огт хэрэгжүүлж чадаагүй
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Үнэ, тарифын бодлого оновчтой, зөв зүйтэй, тогтвортой хэрэгжихүйц хуульчлагдсан эсэх? 2. Үнэ, тарифын бодлогын хэрэгжилтийн талаарх судалгаа 3. Үнэ, тарифыг гадаад валют ам.доллараар хуульчилсан нь оновчтой, зөв зүйтэй эсэх?
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	Үнэ, тариф тогтоосон шийдвэрүүд, үнэ, тарифын бодлогын хэрэгжилтийн судалгаа

Үнэлсэн байдал

1. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэгдэх 5 төрлийн эрчим хүчний үнэ, тарифын талаар зохицуулалт хийсэн байна. Үүнд:

1. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээгээр тохиролцсон үнэ буюу тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс дамжуулах сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний үнэ, тариф
2. Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж, түгээх сүлжээнд нийлүүлэх үнэ тариф /11.4/
3. Тус хуулийн 11.1 дэх хэсэгт зааснаас бусад сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэсэн эрчим хүчний үнэ, тариф /11.5/
4. Эрчим хүчний системд холбогдох болон горим тохируулагч усан цахилгаан станцын үнэ, тариф /11.6/.
5. Бие даасан үүсгүүрээр үйлдвэрлэх эрчим хүчний үнэ, тариф /11.2. 2019 онд хүчингүй болсонд тооцсон/.

Дээрх үнэ, тарифаас тус хуулийн 11.1 дэх хэсэгт заасан үнэ, тарифын дээд хязгаар, эсхүл дээд доод хязгаарыг хуульд шууд тусган зааж өгсөн байна, харин бусад үнэ, тарифын тухайд аливаа нэг хязгаарыг тогтоогүй боловч Эрчим хүчний зохицуулах хорооноос үнэ, тариф тогтоохдоо баримтлах эсхүл харгалзан үзэх нөхцөл байдлуудыг өөр өөрөөр тус тус зааж өгсөн байна.

Ийнхүү өөрөөр тусгасан байгаа нь тухайн эх үүсгүүрийн онцлогоос хамаарсан байж болох хэдий ч зөв зүйтэй, үндэслэлтэй, нэгдсэн тодорхой бодлогод суурилсан, ямар нэгэн нөлөөлөлд автахгүйгээр бие дааж эрх бүхий байгууллагаас үнэ, тарифыг тогтоох нөхцлийг бүрдүүлэх, ингэхийн тулд баримтлах шалгуур үзүүлэлтийг бий болгож хуульд нарийвлан тусгах шаардлагатай байна.

Дэмжих тарифыг зөвхөн тус хуулийн 11.1 дэх хэсэгт заасан үүсгүүрүүдээр үйлдвэрлэсэн эрчим хүчний үнийн зөрүүг нөхөхөд ашиглана гэсэн байх ба бусад үнэ, тарифуудад дэмжих тарифыг ашиглахгүй байхаар хуульчилсан байна.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг дэмжих тарифаар дэмжихийн давуу тал нь хөрөнгө оруулагчдад үнийн тодорхой байдал, урт хугацааны орлогын тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна, түүнчлэн сэргээгдэх эрчим хүчний технологийг хурдацтай нэвтрүүлэх үйл явцыг дэмжих юм. Түүнчлэн, хэрэглэгчид цэвэр эрчим хүч, илүү тогтвортой эрчим хүчний хангамжийн ашиг тусыг хүртэнэ, иймдээ ч Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар дэмжих тарифыг хэрэглэгчийн үнэнд шингээх загварыг Монгол Улс сонгож хуульчилсан байна.

Харин дэмжих тарифын бодлогын сул тал нь хэрэв тарифыг хэт өндөр тогтоовол цахилгааны төлбөрийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд, ялангуяа бага орлоготой өрхүүдэд ихээхэн хэмжээний санхүүгийн дарамт болно. Үүнээс гадна, технологийн зардлыг

хянаж, бууруулах замаар зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлж, үнийг бууруулдаг байх шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Дамжуулах сүлжээнд холбогдсон...” гэж зөвхөн дамжуулах сүлжээг заасан нь учир дутагдалтай байна. Учир нь цаашдаа тархмал эх үүсгүүрийн хөгжилтэй холбоотойгоор орон нутагт түгээх сүлжээний 35 кВ сүлжээнд тархмал эх үүсгүүр холбогдоно гэсэн үг. Иймд дэд станц бүрийг дамжуулах сүлжээ болгох хүндрэлтэй тул энэхүү хуулийн зохицуулалтад “түгээх” сүлжээнд бас холбох боломжтой байхаар зааж өгөх шаардлагатай байна.

Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тогтоосон үнийн хязгаарын хэмжээ нь олон улсын жишгээс дээгүүр байгаа тул хэрэв ийм үнийг хэвээр үлдээх шаардлагатай тохиолдолд сэргээгдэх эрчим хүчний технологи хөгжиж үнэ хямдарсантай уялдуулах, мөн хуримтлууртай байх хэмжээнд тааруулан үнийг дахин тооцох, бууруулах шаардлагатай.

Тус хуулийн 11.1.2. дахь заалтын дагуу бага чадлын усан цахилгаан станц ашиглалтад ороогүй тул тариф батлаагүй байна. Иймд тухайн заалтыг хэрэгжилтийг хангалтгүй, зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй гэж дүгнэхээр байна.

Энэхүү үнэ тарифын бодлогоор Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийтдээ 45 тусгай зөвшөөрөл олгогдсоноос 9 төсөл хэрэгжсэн байна. Иймд тус хуулийн 11.1, мөн дэмжих тарифын бодлогын талаар тусгасан заалтуудыг хуулийн зорилтдоо тодорхой түвшинд хүрсэн хэдий ч хэрэгжээгүй төслүүд 80 хувьтай байгаа нь тухайн заалтуудыг практикт нийцээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, төслүүдийн дийлэнх олонх нь хэрэгжээгүй зэрэг сөрөг үр дагаварт хүргэсэн гэж дүгнэж байна.

Харин бие даасан үүсгүүрээр үйлдвэрлэх сэргээгдэх эрчим хүчний үнийг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс тогтоох талаар тус хуулийн 11.3 дахь хэсэгт хуульчилсан байсныг 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон, 2015 оны 6 дугаар сарын 19-ний, 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуулиудаар тус тус өөрчлөлт оруулж бие даасан эх үүсгүүрээр үйлдвэрлэсэн үнэ, тарифыг тогтооход харгалзан үзэх нөхцөл байдлын тухай заалтаас хасч, “хэрэглэгчийн” болгож өөрчилсөн байна. Өөрөөр хэлбэл, бие даасан эх үүсгүүрээр үйлдвэрлэх эрчим хүчний үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос ер нь тогтоох эсэх, тогтоох тохиолдолд ямар хязгаар, эсхүл нөхцөл байдал, шалгуур үзүүлэлтийг үндэслэж тогтоох тухай заалт огт тус хуульд байхгүй болсон байна. Иймээс ч Хорооноос энэ төрлийн үнэ, тариф тогтоож байсан тохиолдолд байхгүй байх бөгөөд, түүнчлэн хуулийн 7.3.2-т заасан Засгийн газраас үнийн зөрүүг нөхөн өгөх дэмжлэгийг хуульчилсан ч мөн л амьдралд огт хэрэгжээгүй байна. Энэ нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн үзэл баримтлалын нэг чухал асуудал болох бие даасан эх үүсгүүрийн асуудлыг бүрхэгдүүлж, амьдралд хэрэгжүүлж, үр дүн гарах нөхцөлийг

хязгаарласан хийсэн байна. Иймд энэхүү асуудалтай хамааралтай тус хуулийн 4.1.5, 5.1, 5.2, 7.3, 7.4, 7.5, 7.6 дахь хэсгийн заалтуудын хэрэгжилтийн хангалтгүй, зорилгодоо хүрээгүй, практикт нийцээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж дүгнэхээр байна.

Хэрэглэгчийн үйлвэрлэсэн эрчим хүчийг худалдан авах үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 390 дүгээр тогтоолоор баталж байсан байх бөгөөд үнэ, тариф нь 1 кВт.ц нь өдөр 140.18, шөнө 221.89 төгрөг байсан байна. Энэхүү тогтоолыг Хорооны 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 634 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна. Уг үнэ, тарифыг хэт доогуур тогтоосон нь тухайн үнэ, тарифын бодлогын хэрэгжилтийг хангалттай түвшинд хүргэж чадаагүй гэж дүгнэхээр байна. Одоогоор энэ төрлийн эрчим хүч нийлүүлж байгаа 40 гаруй этгээд л бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээр нь ихэвчлэн нийлүүлсэн эрчим хүчний төлбөрөө авч чаддаггүй авлагатай байдаг байна.[5]

Тус хуулийн 11.5. дахь хэсэгт заасны дагуу газрын гүний дулааны эрчим, биомасс болон энэ хуулийн 11.1-т зааснаас бусад сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний үнийг Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоож байсан тохиолдолд одоогоор гараагүй байна. Иймд заалтуудын хэрэгжилтийг хангалтгүй, зорилгодоо хүрээгүй, практик нийцээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж дүгнэхээр байна.

Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсгийн “Энэ хуулийн 11.1-т заасан үнэ, тарифын хязгаарыг хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно.” гэсэн заалтыг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн. Нэгэнт хуульд заасан үнэ, тарифын хязгаарыг юутай уялдуулж, яаж тогтоох тухай нөхцөлийг заасан заалт нэмсэн нь нэгэнт хуулиар тогтоосон үнэ, тарифт ямар ч үр нөлөө үзүүлж чадахгүй тул ийнхүү нэмэх хэрэгцээ шаардлагагүй байсан байна. Хэрэв хуулиар бус эрх бүхий байгууллагаас тогтоодог үнэ, тариф байсан бол тогтоох шалгуур үзүүлэлт, харгалзан үзэх нөхцөл байдлыг хуульчилж өгөх нь тухайн эрх бүхий этгээд асуудалд үзэмжээр хандаж, эсхүл гадны нөлөөлөлд автаж үндэслэлтэй, бие даасан шийдвэр гаргаж чадахгүй байх нөхцөлийг үүсгэхгүй байх ач холбогдолтой байдаг. Харин тус хуулийн 10 дугаар зүйлд заасан цахилгаан эрчим хүч худалдах, худалдах авах гэрээний үнэ, тарифыг талууд харилцан тохиролцоход хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно гэсэн энэхүү нөхцөл шаардлагыг баримтлахаар байсан бол илүү оновчтой зохицуулалт болох байсан байна. Иймд тус заалт нь зохицуулалтын зорилгодоо хүрээгүй, хэрэгжилт нь хангалтгүй, практикт нийцээгүй ба хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж үнэлэгдэж байна.

Тус хуулийн 11.8-д заасны дагуу экспортлох үйл ажиллагаа явуулах эх үүсгүүр одоогоор байхгүй байна. Иймд тухайн заалтын хэрэгжилтийг хангалтгүй, зорилгодоо хүрээгүй, практик нийцээгүй болон хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж дүгнэхээр байна.

[5] Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлэл, 2024 он

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар үнэ, тарифын асуудлыг хуульчлахдаа нэгдсэн бодлогоор асуудалд хандаагүй, зөвхөн тодорхой төрлийн буюу тус хуулийн 11.1-т заасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрдийг дэмжих тариф болон дээд, эсхүл дээд доод хязгаар тогтоох, ийнхүү тогтоохдоо олон улсын жишиг үнээс дээгүүр тогтоосон г.м. илт дэмжсэн байна. Үүний үр дагаварт, энэхүү 11.1-т заасан сэргээгдэх эрчим хүчний шинэ төслүүдийг хэрэгжүүлэх нөхцөлүүд арилсан сөрөг үр дагаварт хүрсэн байна.

Түүнчлэн, тус хуулийг анх батлахад бие даасан үүсгүүрүүдийг хөгжүүлж, үүгээр эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс алслагдсан суурин газрууд, сумын төвүүдийг эрчим хүчээр хангах үзэл баримтлал, зорилтыг тавьж байсан байх ба хэрэв энэ зорилтдоо хүрч нийт 47 сумын төвийг бие даасан үүсгүүрийн эрчим хүчээр хангаж чадсан бол тухайн үеийн ханшаар 46 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт үүсгэж нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг үр дагавар гарна хэмээн тооцож байсан байна.[6] Гэвч энэхүү үзэл баримтлалаасаа ухарч 2015, 2019 онуудад тус хуульд нэмэлт, өөрчлөлтүүдийг хийсэн нь сэргээгдэх эрчим хүчний салбарт баримтлах бодлого нэгдмэл, тогтвортой бус байгааг мөн харуулж байна.

Үүнээс гадна, тус хуулийн 12.1 дэх хэсэгт “Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 10-аас доошгүй жилийн хугацаанд тогтвортой мөрдөнө” гэж заан тогтоосон үнэ, тарифт 10 жилийн хязгаар тавьсан байсныг “Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө.” гэж 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан нь 10 жил хэмээн зааж зөвхөн тодорхой хугацаанд л өндөр үнэ, тариф тогтоож, цаашид тус салбарын хөгжлийн чиг хандлагаас хамаарч үнэ, тарифыг өөрчлөх уян хатан, оновчтой бодлого баримтлах байсныг ийнхүү байхгүй болгосон нь мөн л тус салбарт баримталж байгаа бодлого тогтворгүй байгааг илтгэн харуулж байна.

Байгаль орчинд ээлгүй, хүлэмжийн хийн ялгарал ихтэй, уур амсгалын өөрчлөлтөд нөлөөлөх эрчим хүчний эх үүсвэрээс татгалзаж ногоон шилжилт хийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээгээ хангах зорилт тавьж 2020 нэхэд цахилгаан эрчим хүчний 20 гаруй хувийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн тусламжтайгаар үйлдвэрлэн гаргах боломжтой[7] хэмээн үзэж байсан хэдий ч сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувь 2020 онд 17 хувь, одоогийн байдлаар буюу 2024 онд ердөө 16 хувийг хангаж чадсан байгаа нь анх тавьсан үзэл баримтлал, бодлогын зорилтууддаа бүрэн гүйцэд хүрээгүй, эрчим хүчний эх үүсвэрийн дутагдалтай байгаа хэдий ч хэт өндөр үнэ, тарифыг урт хугацаанд тодорхой тооны төслүүдэд олгосноос болж цаашид сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн шинэ төсөл

[6] Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн үзэл баримтлал, 4-р тал, Түлш эрчим хүчний сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нарын баталсан, 2007 он.

[7] Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн үзэл баримтлал, 4-р тал, Түлш эрчим хүчний сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нарын баталсан, 2007 он


эхлүүлж чадахгүй байгаа нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаварт хүрсэн байх тул тус хуулийн хэрэгжилтийн үр дагавар ерөнхийдөө сөрөг, хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй гэж дүгнэхээр байна.

2. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийн үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифын бодлогын хэрэгжилтийн талаарх судалгааг хийв. Эдгээр үүсгүүрүүдийн үйлдвэрлэсэн эрчим хүчээ нийлүүлж буй үнэ, түүний үнэ бүрдэлтийн талаар доорх хүснэгтүүдээс харж болно.

Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр буюу салхины 3 цахилгаан станц, нарны 6 цахилгаан станц төвийн бүсийн эрчим хүчний системд жилд дунджаар 670.0 сая кВт ЦЭХ нийлүүлж байгаа ба үүний 21.4 хувийг Нарны цахилгаан станц, 78.6 хувийн Салхины цахилгаан станц тус тус нийлүүлж байна.



Сэргээгдэх эрчим хүчний дундаж үнэ 2023 оны байдлаар Салхины цахилгаан станцад 328 төгрөг, Нарны цахилгаан станцад 543 төгрөг байгаа нь уламжлалт ДЦС болон импортын үнийн дунджаас СЦС-ийн дундаж үнэ 2.6 дахин, НЦС-ын дундаж үнэ 4.3 дахин өндөр байна.




Сүүлийн 4 жилд Төвийн бүсийн эрчим хүчний системд 2,596.6 сая кВт.ц ЦЭХ нийлүүлж, гэрээний үнийн дагуу 867.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан ба 269.9 тэрбум төгрөгийг уламжлалт ДЦС-ууд болон импортын дундаж үнээр тооцсон дүнгээр, 571.8 тэрбум төгрөгийг хэрэглэгчдээс авдаг Сэргээгдэх эрчим хүчний дэмжих тарифаар тус тус бүрдүүлсэн байна.

Сэргээгдэх эх үүсвэрүүдийн орлого бүрдүүлэлтийн судалгаа

д/д	*Онууд*	*Дундаж үнэ*	*Нийлүүлсэн ЦЭХ /мян.кВт.ц/*	*Төлөх төлбөр /сая.төг/*	*Эх үүсвэрийн бүрдүүлэлт /сая.төг/*		*Нийт бүрдүүлэлт /сая.төг/*	*Зөрүү /сая.төг/*
					ДЦС-ийн дундаж үнээр	*Дэмжих тарифаар*		
1	2020	302.62	557,099.5	168,589.5	52,361.8	121,398.0	173,759.8	5,170.3
2	2021	308.15	709,845.5	218,740.9	66,860.3	139,273.8	206,134.1	-12,606.8
3	2022	347.46	661,345.7	229,794.0	66,213.9	150,003.1	216,217.0	-13,577.0
4	2023	373.25	668,338.4	250,583.2	84,437.9	161,094.0	245,531.9	-5,051.4
	Дүн		2,596,629.0	867,707.7	269,873.9	571,768.9	841,642.8	-26,064.9

“Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11.2 дах заалтаар СЭХ-ний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхнө” гэсний дагуу бүрэн нөхөж байгаа ба сүүлийн 4 жилийн дунджаар СЭХ-ний дэмжих тарифын орлогоор 68 хувийг нөхсөн байна.

Сэргээгдэх эрчим хүчний орлогын бүрдүүлэлтийг сүүлийн 4 жилээр авч үзэхэд:



ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 6: МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ, ХАРИУЦЛАГА

Хуулийн заалт	**14 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх** 14.1.Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Эрчим хүчний тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ. **15 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага** 15.1.Энэ хуулийн 7.3.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*
Тогтоосон шалгуур үзүүлэлт	▪ Зорилгод хүрсэн түвшин – хангалтгүй ▪ Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – хангалтгүй ▪ Практикт нийцэж байгаа байдал – хангалтгүй ▪ Бусад үр дагавар
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулийн заалтуудын хэрэгжилтийн талаарх судалгаа 2. Тухайн хуулийн заалтууд зохицуулалтын зорилгодоо хүрч, оновчтой, зөв зүйтэй зохицуулалт хийж чадсан эсэх? 3. Сэргээгдэх эрчим хүчний салбарт үүссэн шүүхийн маргаан талаар хийсэн судалгаа
Харьцуулах арга	▪ Байх ёстой болон одоо байгаа ▪ Он дараалаар судлах
Мэдээлэл цуглуулах	Шүүхийн шийдвэрүүд Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлэл

Үнэлсэн байдал

1. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд

үүссэн маргааны талаарх нарийвчилсан статистик, мэдээллийг Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргуулж авсан болно.

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6, 35 дугаар зүйлийн 35.2-т заасны дагуу Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх үүрэгтэй. Салбарын хэмжээнд нийт 1,066,938 хэрэглэгч байна. Үүний 68.8% буюу 733,747 нь цахилгааны, 31.2% буюу 333,191 нь дулааны хэрэглэгчид байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч (хангагч), хэрэглэгч хоорондын харилцааг холбогдох хууль тогтоомж болон хоорондын байгуулсан гэрээгээр зохицуулах тухай Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасан боловч сүүлийн жилүүдэд хангагч байгууллагад хандахгүйгээр Хороонд болон бусад байгууллагад шууд хандах болсон, мөн холбогдох хуулиудын уялдаа холбоо тодорхойгүй, хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байгаагаас Хороонд ирэх гомдлын тоо ихэсч байна.

Хорооны Хэрэглэгч, орон нутгийн газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харъяаллын дагуу хянан шийдвэрлэх, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус газар нь дулааны хэрэглэгчийн асуудал хариуцсан 2, цахилгааны хэрэглэгчийн асуудал хариуцсан 2, судалгаа, шинжилгээ, хэрэглэгчийн асуудал хариуцсан 1 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус газарт 2020 оны 01 дүгээр сараас 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 91,533 хэрэглэгчийг хамарсан 4360 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд хангагч, хэрэглэгчийн хоорондын маргаантай холбоотой нийт 2.8 орчим тэрбум төгрөгийн төлбөрийг шийдвэрлэжээ. Дээрх хугацаанд ирсэн нийт өргөдөл, гомдлын 69% буюу 2995 нь дулааны эрчим хүчний төлбөр тооцоо, хангамж хэрэглээтэй холбоотой байсан байна.

Хороонд хандаж буй хэрэглэгчдийн харилцааг дүгнэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу хангагч байгууллагын ажилтнуудын харилцаанаас, мөн хууль тогтоомжийн тодорхойгүй зохицуулалтаас, хэрэглэгчийн тухайн үеийн сэтгэл зүйн байдлаас шалтгаалж байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Хорооны харьяалан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын судалгааг доор хүснэгтээр харуулав.

2024.10.25

Ангилал	Он	төрөл, ангилал	1-р улирал			2-р улирал			3-р улирал			4-р улирал			Жилийн дүн			нийт	2020-2024 оны 9 дүгээр сар хүртэл өргөдөл гомдол	
			хангах үйл ажиллагаа	түгээх үйл ажиллагаа	хэмжих хэрэгсэл	хангах үйл ажиллагаа	түгээх үйл ажиллагаа	хэмжих хэрэгсэл	хангах үйл ажиллагаа	түгээх үйл ажиллагаа	хэмжих хэрэгсэл	хангах үйл ажиллагаа	түгээх үйл ажиллагаа	хэмжих хэрэгсэл	хангах үйл ажиллагаа	түгээх үйл ажиллагаа	хэмжих хэрэгсэл		Нэгтгэл	хувь, хэмжээ
Өргөдөл гомдол	2020	Цахилгаан	37	7	0	18	9	0	23	16	0	14	7	0	92	39	-	131	278	6%
		Дулаан	26	15	0	31	11	0	25	15	0	12	12	0	94	53	-	147		
	2021	Цахилгаан	32	6	1	20	7	0	26	7	1	30	5	0	108	25	2	135	198	5%
		Дулаан	11	5	1	23	1	1	5	4	0	6	6	0	45	16	2	63		
	2022	Цахилгаан	18	6	0	29	23	2	60	83	2	160	75	0	267	187	4	458	1,083	25%
		Дулаан	8	162	2	27	289	0	29	7	4	9	88	0	73	546	6	625		
	2023	Цахилгаан	92	75	3	26	53	3	25	51	2	38	56	4	181	235	12	428	1,448	33%
		Дулаан	18	98	0	88	345	5	15	85	0	54	312	0	175	840	5	1,020		
	2024	Цахилгаан	34	44	1	15	33	2	19	62	3				68	139	6	213	1,353	31%
		Дулаан	107	179	5	103	243	16	116	365	6				326	787	27	1,140		
Нийт	Цахилгаан		213	138	5	108	125	7	153	219	8	242	143	4	716	625	24	1,365	4,360	100%
	Дулаан		170	459	8	272	889	22	190	476	10	81	418	0	713	2242	40	2,995		
Хэрэглэгчийн тоо	2020	Цахилгаан			183			162			1,819			43				2,207	4,614	5%
		Дулаан			1,280			175			740			212				2,407		
	2021	Цахилгаан			17			341			4			519				881	5,000	5%
		Дулаан			886			1,316			728			1,189				4,119		
	2022	Цахилгаан			37			65			269			235				606	6,215	7%
		Дулаан			1,544			2,836			359			870				5,609		
	2023	Цахилгаан			1,111			60,350			2,387			4,893				68,741	74,849	82%
		Дулаан			695			2,622			599			2,192				6,108		
	2024	Цахилгаан			314			222			319							855	855	1%
		Дулаан																-		
Нийт	Цахилгаан		1662			61140			4798			5690						73,290	91,533	100%
	Дулаан		4405			6949			2426			4463						18,243		
Хэрэглэгч төлөхөөр шийдвэрлэсэн төлбөрийн хэмжээ (төгрөг)	2020	Цахилгаан	27,949,632.2			2,083,509.0			48,655,666.0			-						78,688,807	485,283,466	22%
		Дулаан	4,019,700.0			259,910,639.0			2,246,777.0			140,417,543.0						406,594,659		
	2021	Цахилгаан	126,100,623.0			91,875,920.0			21,866,089.3			44,926,335.4						284,768,968	1,014,246,651	46%
		Дулаан	95,870,561.0			632,409,559.0			-			1,197,563.4						729,477,683		
	2022	Цахилгаан	40,831,535			3,444,850			153,970			340,111						44,770,466	72,433,513	3%
		Дулаан	7,612,871			13,986,437			1,770,435			4,293,305						27,663,047		
	2023	Цахилгаан				1,552,576												1,552,576	645,691,858	29%
		Дулаан	73,255,056			276,600,986			63,150,910			231,132,331						644,139,282		
	2024	Цахилгаан	7,154,748															7,154,748	7,154,748	0.3%
		Дулаан																-		
Нийт	Цахилгаан		202,036,538.2			98,956,855.0			70,675,725.3			45,266,446.4						416,935,565	2,224,810,236	100%
	Дулаан		180,758,187.1			1,182,907,620.4			67,168,122.0			377,040,741.9						1,807,874,671		
Хэрэглэгчид буцаалт хийхээр шийдвэрлэсэн төлбөрийн хэмжээ (төгрөг)	2020	Цахилгаан	4,122,083.2			4,301,262.7			16,112,168.0			-						24,535,514	56,484,663	11%
		Дулаан	11,938,945.0			8,495,355.6			11,067,805.6			447,043.0						31,949,149		
	2021	Цахилгаан	86,993,339.8			70,478,197.0			77,091,028.3			39,593,714.7						274,156,280	316,249,812	60%
		Дулаан	32,139,068.9			6,119,145.0			3,835,318.5			-						42,093,532		
	2022	Цахилгаан	5,936,411			112,845			2,871,050			1,355,275						10,275,581	23,271,342	4%
		Дулаан	3,576,433			6,570,657			831,729			2,016,942						12,995,761		
	2023	Цахилгаан	8,444,761			337,278			-			199,760						8,981,799	18,306,670	3%
		Дулаан	1,060,476			4,004,209			914,203			3,345,983						9,324,871		
	2024	Цахилгаан			29,000			16,712,240			93,174,519							109,915,759	109,915,759	21%
		Дулаан																-		
Нийт	Цахилгаан		105,525,595.0			91,941,822.9			189,248,764.9			41,148,749.5						427,864,932	524,228,246	100%
	Дулаан		48,714,922.8			25,189,366.7			16,649,055.8			5,809,968.2						96,363,314		
																			2,749,038,482.1	

Тайлбар:

- ✓ **“Хангах үйл ажиллагаа”** гэдэгт цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үүссэн асуудлуудыг;
- ✓ **“Түгээх үйл ажиллагаа”** гэдэгт цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрлийн хүрээнд үүссэн асуудлуудыг;
- ✓ **“Хэмжих хэрэгсэл”** гэдэгт цахилгаан, дулааны тоолуурын ажиллагаанаас шалтгаалсан асуудлуудыг тус тус хамруулсан.

Хороонд ирсэн хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангах, хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг цахимд шилжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанарт хяналт тавих, өргөдөл, гомдлын агуулгыг нарийвчлан судалж дүн шинжилгээ хийх, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж судалгаанд үндэслэн хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилготойгоор 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс “Хэрэглэгчийн дуудлага, өргөдөл, гомдлын бүртгэл, хяналтын нэгдсэн цахим систем” (https://consumer.energy.mn/)-ийг хөгжүүлж ашиглалтад оруулсан байна.

Одоогоор цахим системийг Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд цаашид Монгол Улсын хэмжээнд цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдэд ашиглахаар ажиллаж байгаа юм байна.

2. Хороонд ирсэн маргаанууд нь ихэвчлэн хууль, эрх зүйн маргаан гэхээсээ илүү хэрэглэгчийн өргөдөл, гомдлууд ирдэг байна. Эрчим хүчний зохицуулах хорооны иг үүргийг авч үзвэл энэ төрлийн өргөдал, гомдлыг шийдвэрлэх нь зохимжтой биш байх бөгөөд үүнийг тухайн хангагч, түггэгч байгууллагууд, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах байггууллагууд, эсхүл иргэний шүүх хянан шийдвэрлэдэг байхаар зохицуулах нь илүү оновчтой байна.

Иймд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хамрах цар хүрээг дахин нарийвчлан авч үзэх, зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хоорондын маргааныг шийдвэрлэдэг байхаар өөрчилж сайжруулах шаардлагатай байна. Харин хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээг хангалттай сайн, зохицуулалтын зорилгодоо хүрсэн гэж дүгнэхээр байгаа боловч хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал нь хангалтгүй гэж дүгнэхээр байна.

Тус хуулийн 15 дугаар зүйлд 15.1 дэх хэсэгт 7.3.2-т зааснгы зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан нь зохицуулалтын зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй гэж дүгнэхдэхээр байна. Учир нь, зөвхөн нэг л тохиолдлыг онцлон заасан, бусад тохиолдолд хариуцлага огт хүлээлгэхгүй үр дагаварт хүргэж байна.

3. Сэргээгдэх эрчим хүчний салбарын харилцаанд сүүлийн жилүүдэд үүссэн бүх төрлийн шүүхийн маргааныг судлах нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль нь тухай салбарын харилцааг бүрэн дүүрэн, оновчтойгоор зохицуулж чадаж байгаа эсэх, тухайн хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалтууд бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эдгээрээс үүдэн аливаа сөрөг үр дагавар бий болсон, тухайн хуулийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нэг мөр ойлгомжтой биш, хоорондоо зөрчилтэй зохицуулалтууд байгаа эсэх, эдгээр нь салбарын харилцаанд аливаа сөрөг үр дагаврыг бий болгож байгаа эсэх болон бусад хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг илрүүлэх зорилготой юм.

Эрчим хүчний салбарт сүүлийн 3 жилд гарсан маргааны талаарх судалгааг салбарт үйл ажиллагаа явуулж буй 45 байгууллагаас авлаа. Энэхүү судлагаанаас үзэхэд Эрчим хүчний зохицуулах хорооны оролцсон 30 маргаан, бусад байгууллагууд оролцсон 41 шүүхийн маргаан үүссэн байх ба 106 маргааныг шүүхийн эвлэрүүлэн зуучлахаар шийдвэрлүүлсэн байна. Судалгаанд 34 байгууллагын зүгээс ямар нэгэн шүүхийн маргаан үүсээгүй хэмээн хариу ирүүлсэн байна. Эдгээрээс сэргээгдэх эрчим хүчний салбарын харилцаанд үүссэн маргаан нь .. байгаа нь нийт гарсан маргааны .. хувийг эзэлж байна.

Захиргааны хэргийн маргаан

Эрчим хүчний зохицуулах хорооны оролцсон 30 маргааныг Захиргааны хэргийн шүүхээр сүүлийн 5 жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.[8] Үүний тэн хагас нь тусгай зөвшөөрөл хүчингүй болгосонтой холбоотой маргаан байх бөгөөд эдгээр нь бүгд сэргээгдэх эрчим хүчний төсөлтэй хамааралтай байна. Нөгөө хагас нь үнэ тарифын зохицуулалттай холбоотой байгаа нь сэргээгдэх эрчим хүчний хуулийн харилцаанд хамааралгүй байна.

Эрчим хүчний зохицуулах хороо дээрх маргаануудад хариуцагчаас оролцсон байх бөгөөд эдгээр нь бүгд захиргааны эрх зүйн маргаан байна. Сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар үүссэн маргааны 13 нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаагүй тухай дүгнэлт, тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахаас татгалзаж шийдвэрлэсэн Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэр буюу захиргааны актыг хүчингүй болгуулах, эсхүл илт хууль буст тооцуулах шаардлага бүхий маргаанууд байна. Захиргааны хэргийн шүүхээс эдгээр маргаануудыг бүгдийг нь хариуцагч Эрчим хүчний зохицуулах хорооны талд шийдвэрлэсэн байх буюу нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэхүү судалгаанаас үзэхэд Эрчим хүчний зохицуулах хорооны гаргаж буй шийдвэрүүд нь хууль, эрх зүйн үндэслэлтэй гарч байгааг илтгэн харуулж байна. Гэсэн хэдий ч нэг ижил асуудлаар шүүхийн маргаан их гарч байгаа нь салбарын оролцогч талуудын эрх ашгийг хангах, хуулийн дагуу хүлээж буй үүрэг хариуцлага, шаардлагыг зөв зүйтэй хэрэгжүүлэх талаар мэдээлэл, чиглэл, зөвлөгөөг эрх бүхий байгууллагын зүгээс өгөх, хуулийн хэрэгжилтийг сурталчлах, салбарын хөгжлийн бодлогыг нэгдмэл, тогтвортой, нээлттэй буюу оролцогч талууд оролцоог хангахуйцаар явуулах зэрэг ажлууд дутмаг хийгдэж байж болзошгүй байна.

Иргэний маргаан

Иргэний шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны тухайд сэргээгдэх эрчим хүчний асуудлаар үүссэн маргаан сүүлийн 3 жилд гараагүй байна. Үүссэн маргаан нь 2024 онд Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой, тухайлбал энэхүү гэрээний дагуу цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө төлөөгүйн улмаас үүдэн гарсан 75, 2023 онд 37 маргаан гарсан байна[9]. Үүний дийлэнх нь дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө төлөөгүй маргаан зонхилж байна.

Хуулийн тодорхой нэг заалттай холбогдуулан маргаан байнга үүсч байгаа нь тухайн заалтын зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, зайлшгүй зохицуулах шаардлагтай харилцааг бүрэн гүйцэд зохицуулаагүй, талуудын эрх ашгийг бүрэн гүйцэд харгалзан үзээгүй, эсхүл аль нэг талын эрх ашгийг нэг талыг барьж зохицуулсан

[8] Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан судалгаа, 2024 он
[9] https://shuukh.mn/cases/1/1

байх магадлалтай тул цаашид энэхүү зохицуулалтыг оролцогч талуудын эрх ашгийг жигд хангасан, бүрэн гүйцэд зохицуулалттай болгон нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.